

2015 оны 3 дугаар сарын 18

Албан бус орчуулга

**Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-
2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны
хүрээ**

Агуулга

I. Өмнөх үг	3
II. Зорилго, хүлээгдэж буй үр дүн	7
III. Баримтлах зарчмууд	9
IV. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлүүд	11
Тэргүүлэх чиглэл 1. Гамшгийн эрсдэлийг ойлгох	12
Тэргүүлэх чиглэл 2. Гамшгийн эрсдэлийг удирдах засаглалыг бэхжүүлэх	15
Тэргүүлэх чиглэл 3. Гамшигтай тэмцэх чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд хөрөнгө оруулах	18
Тэргүүлэх чиглэл 4. Гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд бэлэн байдлыг хангах, гамшгийн дараах сэргээн босгох, нөхөн сэргээх үе шатанд “Сайжруулан барих” үйл ажиллагааг хэрэгжүүлэх	21
V. Холбогдох талуудын үүрэг, хариуцлага	24
VI. Олон улсын түншлэл, хамтын ажиллагаа	27

I. Өмнөх үг

1. Гамшгийн эрсдэлийг бууруулах дэлхийн гуравдугаар бага хурал Японы Мияги мужийн Сендай хотноо 2015 оны 3 дугаар сарын 14-18-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015 оноос хойш баримтлах үйл ажиллагааны хүрээг батлан улс орнуудад дараах онцгой боломжийг олгосон. Үүнд:

а) Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015 оноос хойш баримтлах тодорхой, чиглэсэн, алсын хараатай, үйл ажиллагаанд тулгуурласан хөтөлбөрийг батлах;

б) Хёогогийн үйл ажиллагааны хүрээ (2005-2015): “Улс үндэстэн, орон нутгийн гамшигтай тэмцэх чадавхийг бий болгох нь” баримт бичиг¹-ийн хэрэгжилтийг үнэлж, дүгнэж дуусгах;

в) Хёогогийн үйл ажиллагааны хүрээнд гамшгийн эрсдэлийг бууруулах бүс нутгийн болон үндэсний стратеги/бодлого, төлөвлөгөө, гэрээг хэрэгжүүлэх явцад гарсан зөвлөмжүүд, хуримтлуулсан туршлагыг харгалзах;

г) Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015 оноос хойш баримтлах үйл ажиллагааны хүрээг хэрэгжүүлэх үүрэг, амлалтад үндэслэн хамтын ажиллагааны арга хэлбэрүүдийг тодорхойлох;

д) Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015 оноос хойш баримтлах үйл ажиллагааны хүрээний хэрэгжилтийг тогтмол хугацаанд үнэлэх арга хэлбэрүүдийг тодорхойлох.

2. Дэлхийн бага хурлын үеэр улс орнууд гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшигтай тэмцэх чадавхи²-аа бэхжүүлэх асуудлыг тогтвортой хөгжил, ядуурлыг арилгах зорилтын хамт яаралтай шийдвэрлэх, боломжийн хэрээр бүх шатны бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөвт тусгах, холбогдох баримт бичгүүдийн хүрээнд авч үзэхээ дахин дахин илэрхийлж байсан.

Хёогогийн үйл ажиллагааны хүрээ: авсан сургамж, тодорхойлсон алдаа дутагдал, тулгарч буй бэрхшээл

3. “Хёогогийн үйл ажиллагааны хүрээ”-ний хэрэгжилтийн талаарх тайлангуудаас харахад 2005 онд уг баримт бичиг батлагдсанаас хойш орон нутгийн, үндэсний, бүс нутгийн болон дэлхийн нийтийн түвшинд гамшгийн

¹Бага хурлын баримт бичиг 206/6, Corr.1, I бүлэг, II хэсэг.

²Гамшигтай тэмцэх чадавх - аюулд өртсөн систем, олон нийт эсвэл нийгэм нэн чухал үндсэн бүтэц, үйл ажиллагаагаа хамгаалах, сэргээх зэрэг үйл ажиллагааг цаг алдалгүй, үр дүнтэй хэрэгжүүлэх замаар аюулын нөлөөллийг эсэргүүцэх, шингээх, зохицох, нөхөн сэргээх чадвар. (НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газрын “Гамшгийн эрсдэлийг бууруулахтай холбоотой нэр томъёо” 2009(2009 оны 5 дугаар сар, Женев))

эрсдлийг бууруулахад ахиц гарч, аюул³-ын улмаас амь насаа алдагсдын тоо буурсан байна. Гамшгийн эрсдэлийг бууруулах нь ирээдүйд учирч болзошгүй хохирлоос сэргийлэх үр дүнтэй хөрөнгө оруулалт юм.

Гамшгийн эрсдэлийн менежментийг үр дүнтэй хэрэгжүүлэх нь тогтвортой хөгжлийг бий болгоход эерэг нөлөө үзүүлдэг. Улс орнууд гамшгийн эрсдэлийн менежментийн чадавхиа сайжруулж байна. Гамшгийн эрсдэлийг бууруулах дэлхийн болон бүс нутгийн платформууд, олон улсын болон бүс нутгийн хамтын ажиллагааны холбогдох бусад форумууд зэрэг гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр стратегийн зөвлөгөө өгөх, зохицуулалт, түншлэлийг хөгжүүлэх олон улсын механизмууд нь бодлого, стратегийг боловсруулах, мэдлэг дээшлүүлэх, харилцан суралцах, туршлага солилцох арга хэрэгсэл болсон. Хёогогийн үйл ажиллагааны хүрээ нь ерөнхийдөө байгууллага, олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, улс төрийн үүрэг, хариуцлагыг ухамсарлуулах, бүх түвшинд холбогдох талуудын өргөн хүрээтэй үйл ажиллагааг өрнүүлэх, эрчимжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн.

4. Гэсэн хэдий ч өнгөрсөн 10 жилийн хугацаанд гамшгийн улмаас олон хүний амь нас үрэгдэж, хүн ам, олон нийт, улс орны аюулгүй байдал, сайн сайхан аж байдалд сөргөөр нөлөөллөө. Нийтдээ 700 гаруй мянган хүн амь насаа алдаж, 1.4 сая гаруй хүн гэмтэж бэртэн 23 орчим сая хүн орон гэргүй болсон байна. 1.5 тэрбум гаруй хүн гамшигт ямар нэг байдлаар нэрвэгджээ. Эмэгтэйчүүд, хүүхэд, эмзэг бүлгийн иргэд харилцан адилгүй өртсөн байна. Нийт учруулсан хохирлын хэмжээ нь 1.3 их наяд ам.доллар болжээ. Үүнээс гадна 2008-2012 онд 144 сая хүн гамшгийн улмаас нүүн шилжсэн байна. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр гамшгийн давтамж, эрчим нэмэгдэж, тогтвортой хөгжилд саад учруулж байна. Бүх л улс орны ард иргэд, эд хөрөнгийн гамшигт өртөх байдал нь эмзэг байдал⁴ буурахаас илүү хурдтай нэмэгдэж, гамшгийн шинэ эрсдэлийг бий болгохоос гадна, нийгэм, эдийн засаг, эрүүл мэнд, соёл, хүрээлэн буй орчинд богино, дунд, урт хугацаанд ноцтой нөлөөлөн ялангуяа орон нутаг, олон нийтийн түвшинд гамшгийн хохирол улам бүр нэмэгдэж байгааг тоо баримт харуулж байна. Цар хүрээ багатай, удаан эрчимтэй гамшиг давтагдан тохиолдож, иргэд, олон нийт, өрх гэр, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд илүүтэй нөлөөлж, нийт хохирлын ихэнх хувийг бүрдүүлж байна. Бүх улс орнууд нэн ялангуяа гамшгийн улмаас амь насаа алдагсдын тоо, эдийн засгийн хохирлын хэмжээ нь харьцангуй өндөр байдаг хөгжиж буй орнууд санхүүгийн болон хүлээсэн бусад үүргээ биелүүлэхэд ихээхэн хүндрэл бэрхшээл, зардал чирэгдэл учирч байна.

³ Аюул - “Хүн амын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулах, нийгэм-эдийн засгийн үйл ажиллагааг тасалдуулах эсвэл хүрээлэн буй орчинг доройтуулах ноцтой үйл явдал, үзэгдэл эсвэл хүний үйл ажиллагаа юм. Аюулд ирээдүйд гамшиг учруулах нуугдмал нөхцөл байдал хамрагдаж болох бөгөөд янз бүрийн гаралтай: байгалийн (геологийн, ус, цаг уурын, биологийн) эсвэл хүний үйл ажиллагаанаас үүссэн (хүрээлэн буй орчны доройтол, технологийн аюул) байж болно.” гэж Хёогогийн үйл ажиллагааны хүрээнд тодорхойлогдсон.

⁴ Эмзэг байдал - “Олон нийтийн аюулын нөлөөлөлд өртөх байдлыг ихэсгэх биет, нийгэм-эдийн засгийн, хүрээлэн буй орчны хүчин зүйлүүдээр эсвэл үйл ажиллагаагаар тодорхойлогдох нөхцөл байдал” гэж Хёогогийн үйл ажиллагааны хүрээнд тодорхойлогдсон.

5. Ард иргэдийн амь нас, эрүүл мэнд, амьжиргаа, улс орны соёлын өв, нийгэм, эдийн засгийн үнэт зүйл, экосистемийг илүү үр дүнтэй хамгаалахын тулд гамшгийн эрсдэлийг урьдчилан мэдэрч, төлөвлөлттэйгөөр бууруулах замаар гамшигтай тэмцэх чадавхиа бэхжүүлэх нь нэн чухал, яаралтай хэрэгжүүлэх асуудал юм.

6. Гамшигт өртөх байдал, эмзэг байдлыг бууруулах үйл ажиллагааг сайжруулан гамшгийн шинэ эрсдэл үүсэхээс сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бий болгож буй үйл ажиллагаанд хариуцлага тооцох зарчмыг бүх түвшинд хэрэгжүүлэх хэрэгтэй. Ядуурал, тэгш бус байдал, уур амьсгалын өөрчлөлт, цаг агаарын тогтворгүй байдал, төлөвлөлтгүй, хурдацтай явагдаж буй хотжилт, оновчгүй газар ашиглалт зэрэг гамшгийн эрсдэл үүсэхэд нөлөөлж буй далд хүчин зүйлс, мөн хүн ам зүйн өөрчлөлт, хууль, эрх зүйн зохицуулалт сул, эрсдэлийг тооцоогүй бодлого, гамшгийн эрсдэлийг бууруулах хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг зохицуулах, урамшуулах механизм дутагдалтай, ханган нийлүүлэх сүлжээ нарийн төвөгтэй, технологийн боломж хязгаарлагдмал, байгалийн нөөцийн ашиглалт тогтворгүй, экосистемийн доройтол, халдварт болон голомтот өвчин зэрэг нийлмэл хүчин зүйлсийг шийдвэрлэхэд чиглэсэн дорвитой арга хэмжээ авч хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Цаашилбал, үндэсний, бүс нутгийн болон олон улсын хэмжээнд гамшгийн эрсдэлийг бууруулах сайн засаглалыг бэхжүүлэх, гамшгийн хор уршгийг арилгах, нөхөн сэргээх, сэргээн босгох үндэсний бэлэн байдал, зохицуулалтыг үргэлжлүүлэн сайжруулах, олон улсын хамтын ажиллагааны “Сайжруулан барих” загварт тулгуурлан гамшгийн дараах сэргээн босгох ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай.

7. Гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх хүн төвтэй үйл ажиллагааг өргөн хүрээнд хэрэгжүүлэх шаардлагатай. Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг үр дүнтэй, үр нөлөөтэй болгохын тулд олон салбарын олон төрлийн аюулыг тооцсон, хүртээмжтэй болгох хэрэгтэй. Удирдан зохицуулах үүрэг, хариуцлага бүхий Засгийн газрууд бодлого, төлөвлөгөө, стандарт боловсруулах, хэрэгжүүлэхдээ эмэгтэйчүүд, хүүхэд, залуус, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ядуу иргэд, шилжин суурьшигсад, нутгийн уугуул иргэд, сайн дурынхан болон ахмадууд, холбогдох бусад талуудын оролцоог хангах хэрэгтэй. Төрийн, хувийн хэвшлийн болон иргэний нийгмийн байгууллагууд, академи, шинжлэх ухаан, судалгааны байгууллагууд нягт хамтран ажиллаж, хамтын ажиллагааны шинэ боломжуудыг бий болгох, бизнесийн үйл ажиллагаандаа гамшгийн эрсдэлийг тооцдог байх шаардлагатай байна.

8. Улс орнууд, үндэсний болон орон нутгийн засаг захиргаа, түүнчлэн олон нийт, бизнесийн байгууллагуудын гамшгийн эрсдэлийг бууруулах хүчин чармайлтыг дэмжихэд олон улсын, бүсийн, орон нутгийн болон хил орчмын хамтын ажиллагаа чухал үүрэгтэй хэвээр байна. Үр нөлөөтэй дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны хэрэгжилтийг сайжруулахын тулд өнөөгийн механизмуудыг бэхжүүлэх шаардлагатай байж болно. Хөгжиж буй орнууд, ялангуяа буурай хөгжилтэй улсууд, арлын жижиг орнууд, далайд гарцгүй хөгжиж буй болон Африкийн орнууд, тодорхой бэрхшээлтэй тулгараад буй дундаж орлоготой

орнуудын дотоодын нөөц, чадавхийг нэмэгдүүлэхэд онцгойлон анхаарч, олон улсын үүрэг, амлалтын дагуу хоёр талт болон олон талт сувгаар технологи солилцох, санхүүгийн болон техникийн дэмжлэг үзүүлэх, чадавх бэхжүүлэх үйл ажиллагааг зохих журмаар цаг хугацаанд нь тогтвортой хэрэгжүүлж, дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.

9. Хёогогийн үйл ажиллагааны хүрээ баримт бичиг нь гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны нэн чухал заавар, чиглэл болж, Мянганы хөгжлийн зорилтуудыг биелүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулсан. Нөгөө талаар уг баримт бичгийг хэрэгжүүлэх явцад гамшгийн эрсдэлийг бий болгож буй далд хүчин зүйлсийг шийдвэрлэх, үйл ажиллагаа⁵-ны зорилт, эрэмбийг тодорхойлох, бүх түвшинд гамшигтай тэмцэх чадавхийг бэхжүүлэх болон тэдгээрийг хэрэгжүүлэх арга хэрэгслийг бий болгохтой холбоотой цөөнгүй алдаа, дутагдал байгааг тодорхойлсон. Эдгээр нь Засгийн газар болон холбогдох байгууллагууд үйл ажиллагааны хүрээ боловсруулж, харилцан биенээ нөхөх, дэмжих байдлаар хэрэгжүүлэх, гамшгийн эрсдэлүүдийг тодорхойлох, гамшигтай тэмцэх чадавхийг бэхжүүлэхэд хөрөнгө оруулалтыг чиглүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

10. Хёогогийн үйл ажиллагааны хүрээ хэрэгжиж эхлээд 10 жил болсон ч гамшиг тогтвортой хөгжлийг бий болгох хүчин чармайлтад саад учруулсаар байна.

11. 2015 оноос хойш хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, хөгжлийн үйл ажиллагааны санхүүжилт, уур амьсгалын өөрчлөлт болон гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны талаарх засгийн газар хоорондын хэлэлцүүлэг, зөвшилцлүүд нь олон улсын хамтын нийгэмлэгт эрх, үүргээ харилцан хүндэтгэхийн зэрэгцээ бодлого, институт, зорилго, шалгуур үзүүлэлт, хэрэгжилтийн явцыг хэмжих тогтолцоо хоорондын уялдаа холбоог сайжруулах онцгой боломжийг олгож байна. Эдгээр үйл явц хоорондын найдвартай холбоог бий болгосноор гамшигтай тэмцэх чадавхийг бэхжүүлж, ядуурлыг арилгах дэлхий нийтийн зорилгод хүрэхэд хувь нэмэр оруулах болно.

12. Тогтвортой хөгжлийн асуудлаар 2012 онд зохион байгуулагдсан НҮБ-ын бага хурлын үр дүнд гарсан “Бидний хүсч буй ирээдүй” баримт бичигт гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшигтай тэмцэх чадавхийг бэхжүүлэх асуудлыг тогтвортой хөгжил, ядуурлыг арилгах хүрээнд бүх түвшинд яаралтай шийдвэрлэхийг уриалж байсныг санацгаая. Энэхүү бага хурал хүрээлэн буй орчин ба хөгжлийн тухай Риогийн тунхаглалын зарчмуудыг мөн дахин баталгаажуулж байна.

⁵ Хёогогийн үйл ажиллагааны хүрээ (2005-2015)-д тусгасан нэн тэргүүнд хэрэгжүүлэх үйл ажиллагаанууд: (1) Үндэсний болон орон нутгийн түвшинд хүчирхэгжиж, бэхэжсэн байгууллагад үндэслэн нэн тэргүүнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа бол гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа (2) Гамшгийн эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, хяналт шинжилгээ хийх, эрт зарлан мэдээлэх системийг сайжруулах (3) Аюулгүй амьдрах соёл, гамшигтай тэмцэх чадавхийг бүх шатанд бий болгохын тулд эрдэм мэдлэг, авьяас чадвараа ашиглах, санаачлагатай ажиллах (4) Эрсдэлийн далд хүчин зүйлсийг багасгах (5) Хор уршгийг арилгах үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд гамшгийн бэлэн байдлыг хангах.

13. Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх НҮБ-ын Суурь конвенц⁶-ийн мандатыг хүндэтгэхийн зэрэгцээ уур амьсгалын өөрчлөлт нь гамшгийн эрсдэлийг бий болгож буй нэг гол хүчин зүйл гэж үзэн шийдвэрлэх нь гамшгийн эрсдэлийг засгийн газар хоорондын харилцан уялдаатай үйл ажиллагааны явцад учир утгатай хандлагаар бууруулах боломж олгоно.

14. Энэ нөхцөлд гамшгийн эрсдэлийг бууруулахын тулд одоо тулгарч буй хүндрэл бэрхшээлүүдийг шийдвэрлэх, ирээдүйд бэлтгэж дараах асуудлуудад анхаарал хандуулах шаардлагатай. Үүнд: гамшгийн эрсдэлийг ойлгож, үнэлж, хянах, эрсдэл хэрхэн үүссэн шалтгаан болон холбогдох бусад мэдээллийг солилцох; гамшгийн эрсдэлийн засаглал, холбогдох байгууллагууд, салбар хоорондын зохицуулалтыг бэхжүүлэх, тэдний үр дүнтэй, бүрэн оролцоог зохистой түвшинд хангах; иргэд, олон нийт, улс орнуудын эдийн засаг, нийгэм, эрүүл мэнд, соёл, боловсролын салбарын гамшигтай тэмцэх, тэсвэрлэх чадавхийг бэхжүүлэхэд болон хүрээлэн буй орчинд, технологи, судалгааны ажилд хөрөнгө оруулалт хийх; аюулын төрөл бүрээр эрт зарлан мэдээллийн систем, бэлэн байдлыг хангах, хор уршгийг арилгах, сэргээн босгох, нөхөн сэргээх үйл ажиллагааг бэхжүүлэх асуудлууд орно. Үндэсний чадавхийг бэхжүүлэх, үйл ажиллагааг өргөжүүлэхийн тулд хөгжиж буй болон хөгжингүй орнууд, улс орнууд ба олон улсын байгууллага хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх шаардлагатай байна.

15. Энэхүү үйл ажиллагааны хүрээ нь байгалийн болон хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй аюул, хүрээлэн буй орчны, технологийн болон биологийн гаралтай аюулаас үүссэн их, бага цар хүрээ, давтамжтай, гэнэтийн болон удаан явцтай гамшгийн эрсдэлүүдэд хамаарах бөгөөд салбарын, салбар хоорондын хөгжлийн бүх түвшинд аюулын төрлүүдээр гамшгийн эрсдэлийг удирдах зорилготой.

II. Зорилго, хүлээгдэж буй үр дүн

16. Гамшигтай тэмцэх чадавхийг бэхжүүлэх, учрах хохирлыг багасгах талаар тодорхой ахиц дэвшил гарсан хэдий ч гамшгийн эрсдэлийг бодитой бууруулахын тулд ард иргэдийн амь нас, эрүүл мэнд, амьжиргаанд илүүтэй анхаарч, тууштай шургуу ажиллах шаардлагатай. Энэхүү үйл ажиллагааны хүрээ нь Хёогогийн үйл ажиллагааны хүрээний ололт амжилтад тулгуурлан ирэх 15 жилийн хугацаанд дараах үр дүнд хүрэхийг зорьж байна. Үүнд:

Гамшгийн эрсдэл, түүний улмаас хүний амь нас, эрүүл мэнд, амьжиргаа, ард иргэд, бизнес, олон нийт, улс орны эдийн засаг, нийгэм, биет болон соёлын үнэт зүйл, хүрээлэн буй орчинд учрах хохирлын хэмжээг бодитой бууруулах.

⁶Энэхүү үйл ажиллагааны хүрээнд тусгасан уур амьсгалын өөрчлөлтийн асуудлууд нь Уур амьсгалын асуудлаарх НҮБ-ын Суурь конвенцийн эрх, үүрэг, Конвенцэд нэгдсэн талуудын эрх мэдлийн хүрээнд байна.

Энэ үр дүнд хүрэхийн тулд улс орон бүрийн энэхүү үйл ажиллагааны хүрээг бүх түвшинд хэрэгжүүлэх, хяналт тавих, шаардлагатай, таатай орчинг бүрдүүлэхэд улс төрийн удирдлагын идэвхтэй оролцоо, үүрэг, хариуцлага зайлшгүй шаардлагатай.

17. Хүлээгдэж буй үр дүнд хүрэхийн тулд дараах зорилгыг биелүүлэх ёстой. Үүнд:

Аюулд өртөх байдал, гамшигт эмзэг байдлаас урьдчилан сэргийлэх, бууруулах, гамшигийн хор уршгийг арилгах, сэргээн босгох бэлэн байдлыг сайжруулж, гамшигтай тэмцэх чадавхийг бэхжүүлэх эдийн засгийн, бүтцийн, хууль, эрх зүйн, нийгмийн, эрүүл мэндийн, соёлын, боловсролын, байгаль орчны, технологийн, улс төрийн болон институцийн нэгдмэл, харилцан уялдаатай арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх замаар гамшигийн эрсдэлийг бууруулах, шинэ эрсдэл үүсэхээс сэргийлэх.

Энэхүү зорилгыг биелүүлэхийн тулд хөгжиж буй орнууд, ялангуяа буурай хөгжилтэй улсууд, арлын жижиг орнууд, далайд гарцгүй хөгжиж буй орнууд, Африкийн болон тодорхой хүндрэл бэрхшээл тулгарч буй дундаж орлоготой улс орнуудын нэн тэргүүний асуудлуудыг шийдвэрлэхэд шаардлагатай дэмжлэг, арга хэрэгслийг олон улсын хамтын ажиллагааны механизмаар дамжуулан үзүүлэх зэргээр энэхүү үйл ажиллагааны хүрээг хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлэх шаардлагатай.

18. Энэхүү үйл ажиллагааны хүрээнээс хүлээгдэж буй үр дүн, дэвшүүлсэн зорилгыг биелүүлэхэд гарч буй дэлхий нийтийн ахиц дэвшлийг үнэлэхэд дэмжлэг болгон долоон зорилтыг тодорхойлсон. Эдгээр зорилтыг олон улсын түвшинд хэмжих ба шаардлагатай шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах болно.

Үндэсний хэмжээний зорилтууд, шалгуур үзүүлэлтүүд нь энэхүү үйл ажиллагааны хүрээний хүлээгдэж буй үр дүн, дэвшүүлсэн зорилгыг биелүүлэхэд хувь нэмрээ оруулах болно.

Дэлхийн хэмжээний долоон зорилт:

а) 2005-2015 онтой харьцуулахад 2020-2030 онд гамшигийн улмаас амь насаа алдагсдын 100,000 хүн тутамд ноогдох дунджийг бууруулах зорилт тавин 2030 он гэхэд амь насаа алдагсдын тоог бодитой бууруулах.

б) 2005-2015 онтой харьцуулахад 2020-2030 онд гамшигт нэрвэгдэгсдийн 100,000 хүн тутамд ноогдох дунджийг бууруулах зорилт тавин 2030 он гэхэд нэрвэгдэгсдийн тоог бодитой бууруулах⁷.

в) 2030 он гэхэд гамшигийн улмаас учрах эдийн засгийн шууд хохирлын хэмжээг дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүнтэй холбоотойгоор бууруулах.

⁷Нэрвэгдсэн хүмүүсийн ангиллыг Дэлхийн бага хурлаар шийдсэний дагуу Сендайн дараах үйл ажиллагааны явцад боловсруулна.

г) Гамшгийг тэсвэрлэх чадавхийг сайжруулах зэргээр 2030 он гэхэд гамшгийн улмаас нэн чухал дэд бүтэц, суурь үйлчилгээ түүний дотор боловсрол, эрүүл мэндийн байгууламжид учрах хохирлыг бодитой бууруулах.

д) 2020 он гэхэд үндэсний болон орон нутгийн түвшний гамшгийн эрсдэлийг бууруулах стратегитай улс орны тоог бодитой нэмэгдүүлэх.

е) 2030 он гэхэд хөгжиж буй орнуудын энэхүү үйл ажиллагааны хүрээг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардлагатай, тогтвортой дэмжлэгийг үзүүлэх олон улсын хамтын ажиллагааг бодитой сайжруулах.

ё) 2030 он гэхэд аюулын төрөл бүрийг эрт зарлан мэдээлэх систем, гамшгийн эрсдэлийн мэдээлэл, үнэлгээг ард иргэд хүртэх, ашиглах боломжийг бодитой нэмэгдүүлэх.

III. Баримтлах зарчмууд

19. Аюулгүй дэлхийн төлөө Ёкохамагийн стратеги: “Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, гамшгийн аюулыг бууруулах үйл ажиллагааны удирдамж” баримт бичиг, үйл ажиллагааны төлөвлөгөө⁸ болон Хёогогийн үйл ажиллагааны хүрээнд тусгагдсан зарчмуудад үндэслэн энэ удаагийн үйл ажиллагааны хүрээг хэрэгжүүлэхдээ үндэсний онцлогийг харгалзсан, дотоодын хууль тогтоомж, олон улсын өмнө хүлээсэн үүрэг, хариуцлага, амлалтуудад нийцүүлсэн дараах зарчмуудыг удирдлага болгоно. Үүнд:

а) Улс орон бүр олон улсын, бүсийн, бүсчилсэн, хил орчмын болон хоёр талт хамтын ажиллагааны хүрээнд гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах үндсэн чиг үүрэгтэй. Гамшгийн эрсдэлийг бууруулах нь дэлхийн бүх улс орны анхаарал татсан нийтлэг асуудал бөгөөд хөгжиж буй орнууд улс орныхоо нөхцөл байдал, чадавхид тулгуурлан гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний бодлого, үйл ажиллагаагаа үр дүнтэй хэрэгжүүлэх боломжийг олон улсын тогтвортой хамтын ажиллагаагаар улам бүр бэхжүүлж болно.

б) Засгийн газар, төрийн байгууллагууд, холбогдох салбар, талууд үндэсний онцлог, засаглалын тогтолцоондоо тохируулан гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд хүлээх үүрэг, хариуцлагаа тодорхойлох шаардлагатай.

в) Гамшгийн эрсдэлийн менежмент нь хүний хөгжих болон бусад эрхийг дээдлэн ард иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, амьжиргаа, соёлын болон хүрээлэн буй орчны үнэт зүйлийг хамгаалахыг зорьдог.

г) Гамшгийн эрсдэлийг бууруулахын тулд бүх нийтийн оролцоог хангасан түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх шаардлагатай. Түүнчлэн гамшигт харилцан адилгүй өртсөн иргэд, ялангуяа ядуу иргэдэд онцгой анхаарал

⁸ 172/9 Бага хурлын баримт бичиг, I бүлэг, I хэсэг, I хавсралт

хандуулан эрх мэдэл олгож, хүртээмжтэй, ялгаварлан гадуурхалгүй оролцуулах хэрэгтэй. Бүх бодлого хөтөлбөр, практик үйл ажиллагаанд жендер, нас хүйс, хөгжлийн бэрхшээл, соёлын асуудлыг тусган иргэдийн сайн дурын зохион байгуулалттай үйл ажиллагааг сайжруулахад онцгой анхаарал хандуулах хэрэгтэй.

д) Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа, менежмент нь салбарын болон салбар хоорондын, холбогдох байгууллагууд хоорондын үйл ажиллагааг бүх түвшинд уялдуулан зохицуулах механизмаас хамаарах бөгөөд үндэсний, орон нутгийн түвшинд хууль тогтоох болон төрийн гүйцэтгэх бүх байгууллагуудын бүрэн оролцоог хангах, бизнесийн, шинжлэх ухааны байгууллагууд, холбогдох төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг тодорхой тусгах, тэдний харилцан ажиллах, түншлэх, хяналт тавих нөхцлийг бүрдүүлэх ёстой.

е) Үндэсний болон муж улсын засгийн газар, засаг захиргааны удирдан чиглүүлэх, зохицуулах үүрэг зайлшгүй чухал хэвээр боловч орон нутгийн удирдлага, олон нийтийг шаардлагатай нөөц боломж, урамшуулал, шийдвэр гаргах үүрэг, хариуцлагаар гамшгийн эрсдэлийг бууруулах боломжтой болгох шаардлагатай.

ё) Гамшгийн эрсдэлийг бууруулахын тулд нас, хүйс, хөгжлийн бэрхшээлээр ангилсан мэдээлэл, уламжлалт мэдлэгээр баяжуулсан хүртээмжтэй, шинэчлэгдсэн, өргөн хүрээтэй, шинжлэх ухаанд суурилсан, нийтэд зориулсан эрсдэлийн мэдээллийг нээлттэй солилцох, түгээх талаар олон төрлийн аюул, эрсдэлийг тооцсон шийдвэр гаргах шаардлагатай байдаг;

ж) Холбогдох бодлого, төлөвлөгөө, үйл ажиллагаа, механизмыг боловсруулах, сайжруулах, хэрэгжүүлэхдээ тогтвортой хөгжил, өсөлт, хүнсний болон эрүүл мэндийн аюулгүй байдал, уур амьсгалын өөрчлөлт, цаг агаарын тогтворгүй байдал, хүрээлэн буй орчны удирдлага, гамшгийн эрсдэлийг бууруулах хөтөлбөр хоорондын уялдаа холбоог хангахыг зорилго болгох хэрэгтэй. Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа нь тогтвортой хөгжлийг хангахад чухал ач холбогдолтой.

з) Гамшгийн эрсдэлийг бий болгогч хүчин зүйлсүүд цар хүрээний хувьд олон улсын, бүс нутгийн, үндэсний болон орон нутгийн байж болох хэдий ч гамшгийн эрсдэлийг бууруулахад тохиромжтой арга хэрэгслийг тодорхойлохын тулд эрсдэлийн онцлог шинж чанаруудыг ойлгосон байх ёстой.

и) Гамшгийн эрсдэлийг тооцсон төрийн болон хувийн хөрөнгө оруулалтаар эрсдэлийн далд хүчин зүйлсийг шийдвэрлэх нь гамшгийн дараа хор уршгийг арилгах, сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхээс илүү хэмнэлттэй бөгөөд тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулдаг.

й) Гамшгийн дараах сэргээн босгох, нөхөн сэргээх үе шатанд олон нийтийн гамшгийн эрсдэлийн талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэн “Сайжруулан барих”

загвараар гамшгийн эрсдэлийг бууруулах, шинээр бий болохоос сэргийлэх чухал ач холбогдолтой.

к) Дэлхийн хэмжээнд утга төгөлдөр, үр дүнтэй түншлэлийг хөгжүүлэх, хөгжингүй орнууд хөгжлийн албан ёсны тусламжийн үүргээ биелүүлэх зэргээр олон улсын хамтын ажиллагааг цаашид улам бэхжүүлэх нь гамшгийн эрсдэлийн удирдлагыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чухал нөлөөтэй.

л) Хөгжиж буй орнууд, ялангуяа буурай хөгжилтэй орнууд, арлын жижиг хөгжиж буй орнууд, далайд гарцгүй орнууд, Африк тивийн улсууд, гамшгийн эрсдэлийн онцлог хүндрэл бэрхшээл тулгарч буй дундаж орлоготой болон бусад улс орнуудад тэдний нэн тэргүүний хэрэгцээ, шаардлагад нийцсэн санхүү, технологийн, чадавх бэхжүүлэх цагаа олсон, тогтвортой дэмжлэгийг хөгжингүй орнууд, холбогдох түншүүдээс үзүүлэх хэрэгтэй.

IV. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлүүд

20. Хёогогийн үйл ажиллагааны хүрээг хэрэгжүүлэх явцад хуримтлуулсан туршлагад үндэслэн, зорилго, хүлээгдэж буй үр дүнд нийцүүлэн улс орнууд орон нутгийн, үндэсний, бүс нутгийн болон олон улсын түвшинд салбарын болон салбар хоорондын үйл ажиллагааг дараах дөрвөн тэргүүлэх чиглэлд хандуулах шаардлагатай байна. Үүнд:

- 1) Гамшгийн эрсдэлийг ойлгох;
- 2) Гамшгийн эрсдэлийг удирдах засаглалыг бэхжүүлэх;
- 3) Гамшигтай тэмцэх чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд хөрөнгө оруулах;
- 4) Гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд бэлэн байдлыг хангах, гамшгийн дараах сэргээн босгох, нөхөн сэргээх үе шатанд “Сайжруулан барих” үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

21. Улс орнууд, бүс нутгийн болон олон улсын байгууллагууд, холбогдох бусад талууд гамшгийн эрсдэлийг бууруулахдаа эдгээр тэргүүлэх дөрвөн чиглэл тус бүрт хамаарах гол үйл ажиллагаануудыг анхаарч, үндэсний хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн чадавх, нөөц бололцоондоо тохируулан хэрэгжүүлэх хэрэгтэй.

22. Дэлхий нийтийн харилцан хамаарал улам бүр нэмэгдэж, олон улсын хэмжээнд хамтын ажиллагааны таатай орчин бүрдсэн энэ үед нэн ялангуяа хөгжиж буй орнуудад хэрэгжүүлэх арга хэрэгслээ тодорхойлж, бүх түвшинд гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг өрнүүлэх, мэдлэг, чадавхийг хөгжүүлэх шаардлагатай.

Тэргүүлэх чиглэл 1. Гамшгийн эрсдэлийг ойлгох

23. Гамшгийн эрсдэлийн менежментийн бодлого, үйл ажиллагаа нь гамшгийн эрсдэлийг түүний бүх хэмжээс буюу эмзэг байдал, чадавх, хүн ам, эд хөрөнгийн өртөх байдал, аюулын шинж чанар болон хүрээлэн буй орчны хүрээнд ойлгосон ойлголтод үндэслэх ёстой. Ийм мэдлэгийг гамшгийн өмнө эрсдэлийн үнэлгээ хийх, урьдчилан сэргийлэх, аюулыг бууруулах, гамшгийн бэлэн байдлыг хангах, хор уршгийг үр дүнтэй арилгах зорилгод ашиглах боломжтой.

Үндэсний ба орон нутгийн түвшин

24. Дээрх зорилтод хүрэхийн тулд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь чухал. Үүнд:

а) Холбогдох тоо баримт, практик мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх, удирдах, ашиглах явдлыг дэмжих. Хэрэглэгчдийн онцлог хэрэгцээ шаардлагыг харгалзан мэдээллийг түгээх;

б) Суурь мэдээллийг сайжруулах, ашиглалтыг урамшуулах, гамшгийн эрсдэл, эмзэг байдал, чадавх, өртөх байдал, аюулын шинж чанарууд, тэдгээрийн экосистем, үндэсний нөхцөл байдалд нийгэм, орон зайн хүрээнд үзүүлж болзошгүй үр дагаврыг тогтмол үнэлэх;

в) Эрсдэлийн зураглал зэрэг гамшгийн эрсдэлийн байршилтай холбоотой мэдээллийг боловсруулах, тогтмол шинэчлэх, шаардлагын дагуу шийдвэр гаргагчид, олон нийт, гамшгийн эрсдэлтэй ард иргэдэд гео-орон зайн мэдээллийн технологи ашиглан тохиромжтой хэлбэрээр хүргэх;

г) Гамшгийн улмаас учирсан хохирлыг системтэй үнэлж, тэмдэглэх, олон нийтэд хүргэх, нийгэм, эдийн засаг, эрүүл мэнд, боловсрол, хүрээлэн буй орчин болон соёлын өвд үзүүлэх нөлөөллийг үйл явдал-тодорхой аюул-өртөх байдал-эмзэг байдалтай холбон ойлгох;

д) Аюулд өртөх байдал, эмзэг байдал, эрсдэл, гамшиг, хохирлын мэдээллийг олон нийт боломжийн хэрээр чөлөөтэй авдаг болох;

е) Бодит мэдээллийг цаг тухайд нь авах боломжтой болгох, газар зүйн мэдээллийн систем, сансрын болон гамшгийн голомтын мэдээллийг ашиглах, хэмжих хэрэгсэл, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, түгээх боломжоо сайжруулахад мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшлийг ашиглах,

ё) Бүх түвшний төрийн албан хаагчид, иргэний нийгэм, олон нийт, сайн дурынхан, хувийн хэвшлийнхний гамшгийн эрсдэлийг бууруулах мэдлэгийг боловсрол, сургалтын механизмыг ашиглан туршлага, сургамж, ололт амжилтаа харилцан солилцох, сургах замаар сайжруулах;

ж) Шинжлэх ухаан - бодлогыг уялдуулж, гамшгийн эрсдэлийн менежментийн оновчтой шийдвэр гаргахын тулд шинжлэх ухаан, технологийн байгууллагууд,

бодлого боловсруулагчид болон холбогдох бусад талуудын харилцаа, хамтын ажиллагааг дэмжих, сайжруулах;

з) Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх, орон нутгийн онцлог нөхцөл байдал, бусад салбарын үйл ажиллагаанд нийцүүлэн тодорхой салбарын бодлого, стратеги, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэхэд шинжлэх ухааны мэдлэгээс гадна уламжлалт арга ухаан, уугуул орон нутгийн мэдлэг, туршлагыг ашиглах;

и) Байгаа мэдлэг, мэдээллийг нэгтгэх, ач холбогдлыг өсгөх, гамшгийн эрсдэл, аюулын төрөл бүрээр эмзэг байдал болон өртөх байдлыг үнэлэх аргачлал, загвар боловсруулах, ашиглахын тулд шинжлэх ухаан, техникийн чадавхийг бэхжүүлэх;

й) Гамшгийн эрсдэл, нийгэм, эдийн засаг, боловсрол, хүрээлэн буй орчны асуудлууд, саад бэрхшээл, сул тал, харилцан хамаарлыг шийдвэрлэхийн тулд гамшгийн эрсдэлийн менежмент, аюулын төрөл бүрээр шийдэлд хүргэх урт хугацааны судалгаа, инноваци, технологийн хөгжилд хөрөнгө оруулахыг дэмжих;

к) Гамшгаас урьдчилан сэргийлэх, аюулыг бууруулах, бэлэн байдлыг хангах, хор уршгийг арилгах, сэргээн босгох, нөхөн сэргээх үйл ажиллагааг хамарсан гамшгийн эрсдэлийн тухай ойлголт, мэдлэгийг албан болон албан бус боловсрол, бүх түвшний иргэний боловсрол, мэргэжлийн боловсрол, сургалтанд тусгах ажлыг дэмжих;

л) Олон нийтийн онцлог, хэрэгцээ шаардлагыг тусгасан кампанит ажил зохион байгуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах зэргээр олон нийтийн гамшгийн эрсдэлийг бууруулах мэдлэг, мэдээлэл, боловсрол, ойлголтыг дээшлүүлэх үндэсний стратегийг дэмжих;

м) Гамшгийн эрсдэлийг бууруулах бодлого боловсруулах, хэрэгжүүлэхдээ иргэд, олон нийт, улс орон, эд хөрөнгийн эмзэг байдал, чадавх, өртөх байдал, аюулын шинж чанар зэрэг эрсдэлтэй холбоотой бүх мэдээллийг ашиглах;

н) Гамшгийн эрсдэлийн мэдээллийг олон нийтэд түшиглэсэн байгууллагууд, төрийн бус байгууллагуудын оролцоотой түгээхийн тулд орон нутгийн иргэд хоорондын харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх.

Олон улсын болон бүс нутгийн түвшинд

25. Дээрх зорилтод хүрэхийн тулд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь чухал. Үүнд:

а) Гамшгийн улмаас учирсан хохирол, холбогдох тоо баримт, статистик мэдээллийг бүртгэх, солилцох, гамшгийн эрсдэлийг загварчлах, үнэлэх, зураглал гаргах, хянах, аюулын төрөл бүрийг эрт зарлан мэдээлэх системийг бэхжүүлэх шинжлэх ухааны аргачлал, арга хэрэгслийг бий болгох, түгээх явдлыг сайжруулах;

б) Аюулын төрөл бүрийг тооцсон гамшгийн эрсдэлийн иж бүрэн судалгаа хийх, уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг багтаасан бүс нутгийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ, зураглал хийх ажлыг дэмжих;

в) Олон улсын хамтын ажиллагаа, технологи солилцоогоор нийтэд зориулсан тоо баримт, мэдээлэл, боломжтой бол харилцаа холбоо, гео орон зай, сансрын технологи, холбогдох бусад үйлчилгээг авах, солилцох боломжийг дэмжих, сайжруулах. Гамшгийн голомтын болон газар дэлхий, уур амьсгалыг алсаас тандах ажиглалтыг зохион байгуулах, сайжруулах. Олон нийтийн мэдээллийн сүлжээ, уламжлалт мэдээллийн хэрэгсэл, их хэмжээний өгөгдлийн болон үүрэн холбооны сүлжээний ашиглалтыг сайжруулах замаар улс орнуудын гамшгийн эрсдэлийн талаарх мэдээллийг үндэсний хууль, тогтоомжийн дагуу амжилттай түгээх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

д) Шинжлэх ухаан, технологийн байгууллагууд, академи, хувийн хэвшилтэй хамтран олон улсын хэмжээнд сайн туршлагаа харилцан солилцох, түгээн дэлгэрүүлэх хүчин чармайлтыг дэмжих;

е) Гамшгийн эрсдэлийг бууруулах сайн туршлага, өртөг-зардал хэмнэсэн, хэрэглэхэд хялбар технологи, бодлого, төлөвлөгөө болон үйл ажиллагаатай холбоотой сургамжийн талаар мэдээлэл солилцох олон улсын, бүс нутгийн, үндэсний болон орон нутгийн түвшинд хэрэглэх боломжтой систем, үйлчилгээг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

ё) Гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чадавхтай, хариуцлагатай иргэншлийн соёлыг бий болгох, гамшгийн эрсдэлийн талаар ойлголт өгөх, харилцан суралцах, туршлага солилцох үйл ажиллагааг дэмжихийн тулд хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, туршлагадаа (тухайлбал, “Нэг сая аюулгүй сургууль болон эмнэлэг” санаачилга, “Хотуудын чадавхийг бэхжүүлэх нь: Манай хот бэлэн болж байна!” кампанит ажил, НҮБ-ын гамшгийн эрсдэлийг бууруулах Сасакавагийн шагнал, НҮБ-аас жил бүр тэмдэглэдэг Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын өдөр) тулгуурлан олон нийтийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх олон улсын, бүс нутгийн хэмжээний үр дүнтэй кампанит ажил явуулах. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн холбогдох талуудыг эдгээр санаачилга, үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах, орон нутгийн, үндэсний, бүс нутгийн болон олон улсын түвшинд шинэ үйл ажиллагаа хэрэгжүүлэх;

ж) Энэхүү үйл ажиллагааны хүрээг хэрэгжүүлэхэд дэмжлэг болох баримт нотолгоо-үндэс суурийг бэхжүүлэх; гамшгийн эрсдэлийн төлөв, шалтгаан ба үр нөлөөнд шинжлэх ухааны судалгаа хийхийг дэмжих; гео-орон зайн мэдээллийн технологийг түлхүү ашиглан эрсдэлийн мэдээллийг түгээх; гамшгийн эрсдэлийн үнэлгээний аргачлал, стандарт, эрсдэлийн загварчлал, өгөгдлийн ашиглалтын талаарх зааварчилгаагаар хангах; гамшгийн эрсдэлийг бууруулахтай холбоотой судалгааны ажил, технологийн сул талыг тодорхойлох, судалгааны тэргүүлэх чиглэлүүдийн талаар зөвлөмж боловсруулах; шинжлэх ухаан, технологийг шийдвэр гаргахад ашиглах боломжийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх; НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын стратегийн газраас 2009 онд гаргасан

“Гамшгийн эрсдэлийг бууруулахтай холбоотой нэр томъёо”-г шинэчлэн сайжруулахад хувь нэмэр оруулах; гамшгийн дараах дүгнэлт, тайлан материалыг суралцах, төрийн бодлогыг сайжруулах боломж талаас нь харж ашиглах; сургалт, судалгааны материалыг түгээн дэлгэрүүлэхийн тулд НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын стратегийн газрын Шинжлэх ухаан, техникийн зөвлөлдөх бүлгийн дэмжлэгтэйгээр бүх бүс нутаг, бүх түвшинд хэрэгжиж буй сүлжээ, шинжлэх ухааны судалгааны байгууллагуудын зохицуулалтаар гамшгийн эрсдэлийг бууруулах шинжлэх ухаан, техникийн ажлыг сайжруулах.

з) Шаардлагатай бол хэлэлцэн тохиролцож, зохиогчийн эрх, патенттай материалуудын хүртээмжийг сайжруулах.

и) Гамшгийн эрсдэлийн менежментийг хөгжүүлэх инноваци, технологи, аюулын төрлүүдийг тооцсон, шийдэлд чиглэсэн урт хугацааны судалгааны ажлыг дэмжих, хүртээмжийг сайжруулах.

Тэргүүлэх чиглэл 2. Гамшгийн эрсдэлийг удирдах засаглалыг бэхжүүлэх

26. Гамшгийн эрсдэлийн үндэсний, бүсийн болон олон улсын түвшний засаглал нь гамшгийн эрсдэлийг үр дүнтэй удирдахад чухал ач холбогдолтой. Алсын хараа, төлөвлөгөө, чадавх, заавар чиглэл, салбарын болон салбар хоорондын зохицуулалт, холбогдох талуудын оролцоо тодорхой байх шаардлагатай. Иймээс гамшгаас урьдчилан сэргийлэх, аюулыг бууруулах, бэлэн байдлыг хангах, хор уршгийг арилгах, сэргээн босгох, нөхөн сэргээхийн тулд гамшгийн эрсдэлийн засаглалыг бэхжүүлэх шаардлагатай бөгөөд тогтвортой хөгжил, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх механизм, байгууллагуудын түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлдэг.

Үндэсний ба орон нутгийн түвшинд

27. Дээрх зорилтод хүрэхэд дараах үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх нь чухал. Үүнд:

а) Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг салбарын ба салбар хоорондын үйл ажиллагаанд уялдуулан тусгах. Үндэсний хууль тогтоомж, орон нутгийн дүрэм, журам, бодлогыг нягталж, уялдаа холбоог сайжруулах, боломжтой бол боловсронгуй болгон үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, төрийн болон хувийн хэвшлийг дараах үйл ажиллагаанд чиглүүлэх. Үүнд: 1) төрөөс өмчилж, удирдан зохицуулдаг дэд бүтэц, үйлчилгээний гамшгийн эрсдэлийг бууруулах; 2) хувь хүн, өрх гэр, олон нийт, бизнесийн байгууллагын үйл ажиллагааг дэмжих, урамшуулах; 3) санхүүгийн урамшуулал, олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх ба сургалтын үйл ажиллагаа, тайланд тавигдах шаардлага, эрх зүйн болон захиргааны арга хэмжээ зэргийг агуулсан гамшгийн эрсдэлийн ил тод байдлыг хангах механизм, санаачлагыг хөгжүүлэх; 4) байгууллагын бүтэц, зохицуулалтыг бий болгох;

б) Эрсдэлийг бууруулах, шинэ эрсдэл үүсэхээс сэргийлэх, нийгэм, эдийн засаг, эрүүл мэнд, хүрээлэн буй орчны чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн цаг хугацааны ялгавартай зорилт, шалгуур үзүүлэлт, гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний ба орон нутгийн стратеги, төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэх;

в) Үндэсний болон орон нутгийн түвшний гамшгийн эрсдэлийг удирдах техникийн, санхүүгийн ба захиргааны чадавхийн үнэлэх;

г) Газар ашиглалт, хот төлөвлөлт, барилгын норм, стандарт, хүрээлэн буй орчин, нөөцийн менежмент, эрүүл мэнд, аюулгүй байдлын стандартыг шийдвэрлэх салбарын хууль, дүрэм журмын аюулгүй байдлыг сайжруулахтай холбоотой заалтуудыг ягштал баримтлуулахад шаардлагатай механизм болон урамшууллыг бий болгох асуудлыг дэмжих, гамшгийн эрсдэлийн менежментэд чиглүүлэх, шаардлагатай бол шинэчлэн сайжруулах;

д) Үндэсний болон орон нутгийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах, тогтмол үнэлэх, олон нийтэд тайлагнах механизмыг хөгжүүлэх, бэхжүүлэх. Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний болон орон нутгийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар парламентын гишүүд, холбогдох бусад албаны хүмүүсийг оролцуулсан хэлэлцүүлгийг зохион байгуулах, олон нийтийн судалгааг дэмжих;

е) Холбогдох хууль, эрх зүйн хүрээнд гамшгийн эрсдэлийн менежментийн институт, үйл явц, шийдвэр гаргах үйл ажиллагаанд шаардлагатай бол олон нийтийн төлөөллийг томилж, тодорхой үүрэг, хариуцлага хүлээлгэх. Хууль, дүрэм журмыг боловсруулах явцад иргэд, олон нийтийн хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж, хэрэгжилтийг нь дэмжих;

ё) Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний болон орон нутгийн платформ зэрэг үндэсний болон орон нутгийн түвшний холбогдох талуудаас бүрдсэн засгийн газрын зохицуулалтын форумыг бий болгох, бэхжүүлэх, 2015 оноос хойшхи үйл ажиллагааны хүрээг үндэсний хэмжээнд хариуцан хэрэгжүүлэгчийг тодорхойлох. Ийм механизм нь үндэсний институцийн хүрээнд бат бөх суурьтай, дараах тодорхой эрх, үүрэгтэй байна. Үүнд: салбарын болон салбар хоорондын гамшгийн эрсдэлийг тодорхойлох, нийтийн зориулалттай гамшгийн эрсдэлийн мэдээлэл, өгөгдлийг солилцох, түгээх замаар гамшгийн эрсдэлийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, үндэсний ба орон нутгийн түвшний гамшгийн эрсдэлийн мэдээллийг зохицуулах, хувь нэмэр оруулах, гамшгийн эрсдэлийн талаар олон нийтэд мэдлэг, ойлголт өгөх кампанит ажлыг зохицуулах, орон нутгийн түвшинд салбар хоорондын хамтын ажиллагааг зохион байгуулах, дэмжих (жишээлбэл, орон нутгийн засаг захиргааны хооронд), үндэсний, орон нутгийн гамшгийн эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, холбогдох бүх бодлогыг тодорхойлох, хэрэгжилтийг тайлагнахад хувь нэмэр оруулах. Эдгээр үүрэг, хариуцлагыг хууль, дүрэм, журам, стандартад нийцүүлэн тодорхойлно.

ж) Гамшгийн эрсдэлийн менежментийн хүрээнд иргэний нийгэм, олон нийт, нутгийн уугуул иргэд, шилжин суурьшигсадтай хамтран ажиллах, үйл ажиллагааг

нь зохицуулахын тулд орон нутгийн засаг захиргааг эрх зүйн болон санхүүгийн арга хэрэгслээр чадавхжуулах;

з) Холбогдох хууль, эрх зүйн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах, эсвэл шинээр боловсруулах, төсөв хуваарилах зэргээр гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд Парламентын гишүүдийн дэмжлэгийг өрнүүлэх;

и) Хувийн хэвшил, иргэний нийгэм, мэргэжлийн холбоод, шинжлэх ухааны байгууллагууд, НҮБ-ын оролцоотойгоор гамшгийн эрсдэлийн менежментэд гэрчилгээ, шагнал урамшуулал олгох зэргээр чанарын стандартыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

й) Үндэсний хууль, эрх зүйн системийн хүрээнд хэрэгцээ, шаардлагын дагуу гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлтэй бүсэд байгаа хүн амыг нүүлгэн суурьшуулах асуудлыг шийдэхэд чиглэсэн төрийн бодлого боловсруулах.

Дэлхийн ба бүс нутгийн түвшинд

28. Дээрх зорилтод хүрэхийн тулд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь чухал. Үүнд:

а) Энэхүү үйл ажиллагааны хүрээнд төлөвлөлтийн үр ашгийг нэмэгдүүлэх, мэдээллийн нэгдсэн систем бий болгох, ялангуяа нийтлэг болон хил дамнасан гамшгийн эрсдэлийг шийдвэрлэх чадавхийг сайжруулах, хамтын ажиллагааны хөтөлбөр хөгжүүлэх, сайн туршлагаас хуваалцахын тулд гамшгийн эрсдэлийг бууруулах бүсийн ба бүсчилсэн хамтын ажиллагааны стратеги, механизмын тусламжтай бүсийн хэмжээний үйл ажиллагааг удирдан чиглүүлэх;

б) Гамшгийн эрсдэлийг бууруулахтай холбоотой тухайлбал, уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдал, тогтвортой хөгжил, ядуурлыг арилгах, хүрээлэн буй орчин, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, хүнс, шим тэжээл болон бусад асуудалтай холбоотой арга хэрэгслийг хэрэгжүүлэх, уялдаа холбоог хангахын тулд олон улсын болон бүсийн механизм, институц хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх;

в) Түншлэлийг хөгжүүлэх, гамшгийн эрсдэлийг тооцсон бодлого, хөтөлбөр, хөгжлийн болон уур амьсгалын асуудлаарх зэрэг хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн явцыг тогтмол үнэлэх, мэдлэг, туршлагаа солилцох, гамшгийн эрсдэлийн менежментийг холбогдох бусад салбарын үйл ажиллагаанд тусгахад дэмжлэг үзүүлэхийн тулд Гамшгийн эрсдэлийг бууруулах дэлхийн болон бүсийн, бүсчилсэн платформууд, сэдэвчилсэн бусад платформуудад идэвхтэй оролцох. Бүсийн Засгийн газар хоорондын байгууллагууд гамшгийн эрсдэлийг бууруулах бүсийн платформуудад чухал үүрэгтэй оролцох хэрэгтэй;

г) Гамшигтай тэмцэх чадавхийг бэхжүүлэх, гоц халдварт өвчин, шилжилт хөдөлгөөн зэргийн эрсдэлийг бууруулах зорилгоор голын сав газрын болон эрэг дагуух дундын нөөцтэй экосистемд суурилсан бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэх, хил дамнасан хамтын ажиллагааг дэмжих;

д) Сонирхсон улсууд хоорондын сайн дурын үнэлгээ хийх үйл явцаар харилцан суралцах, сайн туршлага, мэдээлэл солилцохыг дэмжих;

е) Хёогогийн үйл ажиллагааны хүрээний хэрэгжилтийг хянасан туршлагад тулгуурлан холбогдох мэдээлэл, өгөгдлийг тусган гамшгийн эрсдэлийг үнэлэх, хяналт тавих олон улсын сайн дурын механизмыг бэхжүүлэх. Энэхүү механизм нь төрийн холбогдох байгууллагууд, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийн чиглэлийн байгууллагуудад гамшгийн эрсдэлийн талаарх нийтийн зориулалттай мэдээлэл солилцох боломж олгодог.

Тэргүүлэх чиглэл 3. Гамшигтай тэмцэх чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд хөрөнгө оруулах

29. Дээрх зорилтод хүрэхийн тулд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь чухал. Үүнд:

а) Бүтцийн болон бүтцийн бус арга хэмжээг хэрэгжүүлэн гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулахад төр, хувийн хэвшлээс оруулж буй хөрөнгө оруулалт нь ард иргэд, олон нийт, улс орон, эд хөрөнгө, нийгэм, эдийн засаг, эрүүл мэнд, соёлын чадавх, хүрээлэн буй орчныг бэхжүүлэхэд чухал үүрэгтэй. Эдгээр нь шинийг санаачлах, өсөлт хөгжил, ажлын байр бий болоход нөлөөлөх бөгөөд ард иргэдийн амь насыг хамгаалах, хохирлоос урьдчилан сэргийлэх, бууруулах, сэргээн босгох, нөхөн сэргээх арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх, зардалд хэмнэлттэй чухал ач холбогдолтой арга хэмжээ юм.

Үндэсний ба орон нутгийн түвшинд

30. Дээрх зорилтод хүрэхийн тулд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь чухал. Үүнд:

а) Холбогдох бүх салбарт гамшгийн эрсдэлийг бууруулах стратеги бодлого, төлөвлөгөө, хууль, дүрэм журмыг боловсруулах, хэрэгжүүлэхэд засаг захиргааны бүх шатны байгууллагад санхүү, ложистикийн болон шаардлагатай бусад нөөцийг хуваарилах;

б) Гамшгийн улмаас засгийн газар, хот, хөдөөд учирч буй санхүүгийн нөлөөллийг багасгахын тулд төрийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих, гамшгийн эрсдэлийг шилжүүлэх, даатгах, хуваалцах, тогтоон барих санхүүгийн хамгаалалтын механизмуудыг ашиглах;

в) Гамшигтай тэмцэх, гамшигийг тэсвэрлэх чадавхтай төрийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг бэхжүүлэх, ялангуяа дараах үйл ажиллагаануудад чиглүүлэх. Үүнд: нэн чухал байгууламж, тухайлбал сургууль, эмнэлэг, биет дэд бүтцүүдэд гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах бүтцийн, бүтцийн бус болон үйл ажиллагааны арга хэмжээг хэрэгжүүлэх; барилгын материалын стандарт, дэлхий нийтээр мөрддөг зарчмуудын дагуу зөв загвар, хийцээр эхнээс

нь аюулд тэсвэртэй барилга байгууламжийг барих; хүчитгэн дахин барих; засвар үйлчилгээ хийх ашиглалтын соёлыг хөгжүүлэх; нийгэм, эдийн засаг, бүтцийн, технологийн болон хүрээлэн буй орчны нөлөөллийн үнэлгээг харгалзах;

г) Түүх, соёлын өв, шашин шүтлэгтэй холбоотой бусад газруудыг хамгаалах, хамгаалахад дэмжлэг үзүүлэх;

д) Бүтцийн ба бүтцийн бус арга хэмжээ авах замаар ажлын байруудын гамшгийн эрсдэлийг тэсвэрлэх чадавхийг дээшлүүлэх;

е) Гамшгийн эрсдэлийн үнэлгээг хот төлөвлөлт, газрын доройтлын үнэлгээ, албан бус түр суурьшлын байгууламж зэрэг газар ашиглалттай холбоотой бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд ашиглах, хүн ам зүй, хүрээлэн буй орчны хүлээгдэж буй өөрчлөлтийг тооцох дүрэм журам, арга хэрэгслийн ашиглалтыг дэмжих;

ё) Хүн ам суурьшихад аюулгүй, экосистемийн үйл ажиллагааг хэвийн хадгалах боломжтой газрыг тодорхойлох зэрэг уул, гол, үерийн аюултай эрэг орчмын бүс, хуурай болон чийглэг газар, ган гачиг, үерт өртөмтгий газруудын менежмент, орон нутгийн хөгжлийн төлөвлөлтөд гамшгийн эрсдэлийн үнэлгээ, зураглал, менежментийг тусгахад дэмжлэг үзүүлэх;

ж) Орон нутгийн түвшинд ялангуяа албан бус, захын суурьшлын бүсэд илүүтэй хэрэглэх зорилгоор үндэсний болон орон нутгийн түвшинд барилгын норм, стандарт, сэргээн босгох, нөхөн сэргээх үйл ажиллагааг хянах, шинэчлэн боловсруулах; гамшигт тэсвэртэй байгууламжуудыг зохих хандлагын дагуу бий болгох зорилгоор норм, стандартыг хэрэгжүүлэх, ажиглах, боловсронгуй болгох чадавхийг дээшлүүлэх,

з) Ялангуяа орон нутгийн түвшинд анхан шатны, хоёрдогч болон гуравдагч шатлалын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд гамшгийн эрсдэлийн менежментийг тусгах; эрүүл мэндийн ажилтнуудын гамшгийн эрсдэлийг ойлгох, үйл ажиллагаандаа эрсдэлийг бууруулах чиг хандлагыг ашиглах чадавхийг дээшлүүлэх, бусад салбартай хамтран орон нутгийн эрүүл мэндийн бүлгүүдийн эрүүл мэндийн хөтөлбөрт гамшгийн эрсдэлийг бууруулах хандлагыг тусгаж сургах, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 2005 онд гаргасан Олон улсын эрүүл мэндийн салбарын журмыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх замаар үндэсний эрүүл мэндийн системийн гамшигтай тэмцэх чадавхийг бэхжүүлэх;

и) Олон нийтийн оролцоог хангаж, амьжиргаа дээшлүүлэх хөтөлбөртэй уялдуулсан бодлого, нийгмийн аюулгүй байдлын сүлжээ, механизмыг бий болгох, хэрэгжүүлэх, ядуурлыг арилгах чиглэлд шинэ төрсөн эх, хүүхдийн эрүүл мэнд, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал, шим тэжээл, амьдрах орон байр, боловсрол зэрэг эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ авах чадавхийг бэхжүүлэх, гамшгийн дараах үе шатанд тогтвортой хэрэгжүүлэх шийдлийг олох, гамшигт харилцан адилгүй өртсөн хүмүүст туслах, тэднийг чадавхжуулах;

й) Бодлого, төлөвлөгөө боловсруулахдаа амь насанд аюултай, ужиг өвчтэй хүмүүсийн онцлог хэрэгцээ, шаардлагыг харгалзан гамшгийн өмнө, үед болон дараа тэдний яаралтай тусламж, үйлчилгээ авах зэрэг эрсдэлийг зохицуулах асуудлыг тусгах хэрэгтэй;

к) Үндэсний хууль, тогтоомж, нөхцөл байдалд нийцүүлэн гамшигт нэрвэгдэгсэд, тэдний оршин буй орон нутгийн гамшигтай тэмцэх чадавхийг бэхжүүлэх зорилгоор гамшгийн үеийн нүүлгэн шилжүүлэлтийг тусгасан бодлого, хөтөлбөрийг батлах;

л) Гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлыг санхүүжилтийн арга хэрэгсэлд тусгах явдлыг дэмжих;

м) Экосистемийн тогтвортой ашиглалт, менежментийг сайжруулах, гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлыг тусгасан хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн нэгдсэн менежментийн чиг хандлагыг хэрэгжүүлэх;

н) Ханган нийлүүлэх системийн бүх шатанд амьжиргаа, үр бүтээмжтэй хөрөнгийг хамгаалах, бизнесийн тэмцэх, тэсвэрлэх чадавхийг дээшлүүлэх. Үйлчилгээний тогтвортой ажиллах баталгааг хангах, гамшгийн эрсдэлийн менежментийг бизнесийн загвар, үйл ажиллагаанд тусгах;

о) Мал, амьтад, багаж хэрэгсэл, үр тариа зэрэг амьжиргааны хэрэгсэл, үр бүтээмжтэй хөрөнгийн хамгаалалтыг сайжруулах;

ө) Эдийн засаг ихэнхдээ аялал жуулчлалын салбараас ихээхэн хамааралтай байдгийг харгалзан аялал жуулчлалын салбарт гамшгийн эрсдэлийн менежментийн асуудлыг тусгах.

Олон улсын ба бүс нутгийн түвшинд

31. Дээрх зорилтод хүрэхийн тулд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь чухал. Үүнд:

а) Тогтвортой хөгжил, гамшгийн эрсдэлийг бууруулахтай холбоотой систем, салбар, байгууллагууд хоорондын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, үйл ажиллагааны уялдааг сайжруулах;

б) Олон улсын хамтын нийгэмлэг, бизнесийн салбар, олон улсын санхүүгийн байгууллагууд болон холбогдох бусад талуудтай нягт хамтран гамшгийн эрсдэлийг шилжүүлэх болон хуваалцах механизм, арга хэрэгслийг бий болгох, сайжруулах ажлыг дэмжих;

в) Гамшгийн эрсдэлийг бууруулахад дэмжлэг үзүүлэх шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, хөгжүүлэх, ялангуяа хөгжиж буй орнуудад тулгарч буй хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэхэд туслах академи, шинжлэх ухаан, судалгааны байгууллагууд, сүлжээнүүд, хувийн хэвшлийн салбарын хамтын ажиллагааг дэмжих;

г) Гамшгийн нийгэм, эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөллийг урьдчилан таамаглах, үнэлэх дэлхийн болон бүсийн санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааны зохицуулалтыг дэмжих;

д) Улс орнуудын гамшгийн эрүүл мэндийн эрсдэлийн менежментийн чадавх, Олон улсын эрүүл мэндийн дүрэм (2005)-ийн хэрэгжилтийг сайжруулах, тэмцэх чадавхтай эрүүл мэндийн систем бий болгохын тулд эрүүл мэндийн байгууллага, холбогдох бусад талуудын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх;

е) Мал, амьтад, багаж хэрэгсэл, үр тариа болон бусад үр бүтээмжтэй хөрөнгийг хамгаалах чиглэлээр хамтран ажиллах, чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагааг дэмжих, бэхжүүлэх;

ё) Өрх, олон нийтийн түвшинд гамшгийн цохилтыг тэсвэрлэдэг болохын тулд амьжиргаа дээшлүүлэх хөтөлбөртэй уялдуулсан, гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг тусгасан нийгмийн аюулгүй байдлын сүлжээг хөгжүүлэхийг дэмжих.

ж) Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаагаар дамжуулан ядуурал, өлсгөлөнг арилгахад чиглэсэн олон улсын хүчин чармайлтыг өргөжүүлэх, бэхжүүлэх;

з) Бизнесийн байгууллагуудын гамшигтай тэмцэх чадавхийг бэхжүүлэх төрийн болон хувийн хэвшлийн холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжих.

Тэргүүлэх чиглэл 4. Гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд бэлэн байдлыг хангах, гамшгийн дараах сэргээн босгох, нөхөн сэргээх үе шатанд “Сайжруулан барих” үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

32. Ард иргэд, эд хөрөнгийн гамшигт өртөх байдал, гамшгийн үед авсан сургамж зэрэг нь гамшгийн эрсдэл тогтвортой өсөж байгааг болон цаашид гамшгийн хор уршгийг арилгах бэлэн байдлыг сайжруулах, шаардлагатай арга хэмжээ авах, гамшгийн эрсдэлийн бууруулах үйл ажиллагааг хор уршгийг арилгах, бэлэн байдлыг хангах арга хэмжээтэй уялдуулах шаардлагатай байгааг харуулж байгаа бөгөөд энэ нь хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагааг бүх түвшинд үр дүнтэй хэрэгжүүлэх чадавхийг бий болгох. Эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг итгэмжлэн хүйсийн тэнцвэртэй байдлыг хангуулах үйл ажиллагааг удирдуулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хор уршгийг арилгах, сэргээн босгох, нөхөн сэргээх хандлагыг хүртэх боломжтой зохион байгуулах. Гамшиг тохиолдохоос өмнө сэргээн босгох, нөхөн сэргээх шатны бэлтгэлийг хангасан байх шаардлагатай бөгөөд энэ шат нь гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг хөгжлийн үйл ажиллагаатай уялдуулах, улс орон, ард иргэдийг гамшигтай тэмцэх чадавхтай болгох, “сайжруулан барих” чухал боломж олгодгийг тохиолдож байсан гамшгууд харуулдаг.

Үндэсний ба орон нутгийн түвшинд

33. Дээрх зорилтод хүрэхийн тулд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь чухал. Үүнд:

а) Бүх салбар, холбогдох талуудын оролцоог хангаж, уур амьсгалын өөрчлөлт, түүний гамшгийн эрсдэлд үзүүлэх нөлөөллийг харгалзан гамшгийн бэлэн байдлын, онцгой байдлын үеийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулах, нягтлах, тогтмол шинэчлэх;

б) Хүн төвтэй, аюулын төрлүүдийг олон салбараар урьдчилан мэдээлэх эрт зарлан мэдээллийн систем, гамшгийн эрсдэлийн болон онцгой байдлын үеийн харилцаа холбооны механизм, олон нийтийн мэдээллийн технологи, аюулыг хянах харилцаа холбооны системд хөрөнгө оруулах, хөгжүүлэх, ажиллуулах, бэхжүүлэх. Эдгээр системийг оролцооны үйл явцаар боловсронгуй болгох. Хэрэглэгчдийн нийгэм, соёлын, ялангуяа жендерийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэх. Энгийн, зардал багатай эрт зарлан мэдээллийн төхөөрөмж, хэрэгсэл ашиглахыг дэмжих, байгалийн гамшгийн эрт зарлан мэдээллийг хүргэх сувгийг нэмэгдүүлэх;

в) Гамшгийн үед болон гамшгийн дараа ард иргэдийн амь насыг аврах, амин чухал бусад үйлчилгээг үзүүлэх, аюулгүй байх, үр дүнтэй ажиллах баталгааг хангахын тулд ус, зам тээвэр, харилцаа холбооны дэд бүтэц, сургууль, эмнэлэг, эрүүл мэндийн бусад байгууламжийн өнөөгийн болон шинээр баригдах нэн чухал дэд бүтцийн гамшигт тэсвэртэй байх чадавхийг бэхжүүлэх;

г) Олон нийтийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, аврах, яаралтай тусламжийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай материалуудыг нөөцлөх олон нийтийн төвүүдийг байгуулах;

д) Яаралтай тусламжийн зохицуулалт, санхүүжилтийн механизм, журмыг бий болгох, сайжруулах, гамшгийн дараах сэргээн босгох, нөхөн сэргээх ажиллагааг төлөвлөх, бэлтгэх төрийн албан хаагчдын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх төрийн бодлого, үйл ажиллагааг батлах;

е) Онцгой байдлын үед хор уршгийг арилгах үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд ажиллах хүч, сайн дурын ажилтнуудаа гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагаанд сургах, техник, ложистикийн чадавхийг бэхжүүлэх;

ё) Гамшгийн дараах үе шатанд нийгэм, эдийн засгийг сэргээн босгох, суурь үйлчилгээгээр хангах зэрэг асуудлыг тусгасан төлөвлөлт, үйл ажиллагаа тасалдахгүй хэрэгжих нөхцлийг хангах;

ж) Нүүлгэн шилжүүлэх дасгал сургууль зэрэг гамшгийн бэлэн байдал, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагааны дадлагыг тогтмол зохион байгуулах, гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагааг яаралтай, үр дүнтэй хэрэгжүүлэх, шилжих хөдөлгөөнтэй холбоотой түр хоргодох аюулгүй байр, нэн шаардлагатай хүнс, орон нутгийн онцлогт тохирсон яаралтай тусламжийн зүйлсийн хүртээх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор бүсчилсэн дэмжлэг үзүүлэх тогтолцоог бий болгох;

з) Гамшгийн дараах сэргээн босгох нарийн төвөгтэй, зардал өндөртэй үйл ажиллагааг үндэсний эрх бүхий байгууллагуудын зохицуулалтын дор гамшигт нэрвэгдсэн иргэд, бизнесийн болон бусад байгууллагууд, эрх бүхий албан тушаалтнууд, холбогдох талууд бүх түвшинд хамтран хэрэгжүүлэх явдлыг хөхиүлэн дэмжих;

и) Гамшгийн эрсдэлийн менежментийг гамшгийн дараах сэргээн босгох, нөхөн сэргээх үйл явцад тусгах, яаралтай тусламж үзүүлэх, нөхөн сэргээх болон хөгжлийн үйл ажиллагаа хоорондын уялдааг хангахад дэмжлэг үзүүлэх. Газар ашиглалтыг төлөвлөх, барилга байгууламжийн стандартыг сайжруулах, мэдлэг, туршлага солилцох, гамшгийн дараах үйл ажиллагааны дүгнэлт, сургамж зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж, гамшгийн эрсдэлийг урт, дунд, богино хугацаанд бууруулах чадавхийг хөгжүүлэх боломжийг сэргээн босгох үе шатанд ашиглах. Гамшгийн дараах сэргээн босгох үйл ажиллагааг нэрвэгдсэн газруудын нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийн үйл явцтай уялдуулах. Үүнийг мөн гамшгийн улмаас орон гэргүй болсон хүмүүсийн түр хоргодох байранд ашиглах.

й) Хёогогийн үйл ажиллагааны хүрээ баримт бичиг батлагдсаны дараах 10 жилийн хугацааны сэргээн босгох, нөхөн сэргээх хөтөлбөрүүдээс авсан сургамж, бусдын туршлага, мэдлэг сургамжид тулгуурлан газар ашиглалтыг төлөвлөх, барилга байгууламжийн стандартыг сайжруулах талаар сэргээн босгох үйл ажиллагааны бэлэн байдлыг хангахад чиглэсэн зааварчилгаа боловсруулах;

к) Гамшгийн дараах сэргээн босгох үе шатанд холбогдох хүмүүстэй зөвшилцсөний үндсэн дээр дэд бүтэц, нийтийн үйлчилгээг эрсдэлтэй газраас боломжтой газар шилжүүлэн байршуулах асуудлыг анхаарч үзэх;

л) Гамшигт өртөмтгий газарт амьдарч буй хүмүүсийг нүүлгэн шилжүүлэх орон нутгийн засаг захиргааны чадавхийг бэхжүүлэх;

м) Өвчлөл, нас баралтаас урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулахын тулд гамшгийн тохиолдлыг бүртгэх механизм, амь насаа алдсан болон холбогдох бусад мэдээллийг агуулсан мэдээллийн санг бий болгох;

н) Шаардлагатай бүх хүмүүст сэтгэл зүйн дэмжлэг, сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх нөхөн сэргээх хөтөлбөрийг өргөжүүлэн хөгжүүлэх;

о) Олон улсын гамшгийн яаралтай болон эрт үеийн сэргээн босгох тусламжийн ажиллагааг дотооддоо зохицуулах удирдамж, зааварт үндэслэн олон улсын хамтын ажиллагаатай холбоотой үндэсний хууль, дүрэм журмыг нягтлах, сайжруулах.

Олон улсын ба бүс нутгийн түвшинд

34. Дээрх зорилтод хүрэхийн тулд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь чухал. Үүнд:

а) Үндэсний тэмцэх чадавхиас давсан нөхцөл үүссэн үед гамшгийн хор уршгийг арилгах арга хэмжээг шуурхай, үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх, бэлэн байдлыг хангахын тулд бүс нутгийн зохицуулалттай хандлага, үйл ажиллагааны механизм бий болгох, бэхжүүлэх;

б) Гамшгийн бэлэн байдлыг хангах, хор уршгийг арилгах зохицуулалттай үйл ажиллагаа болон гамшгийн дараах сэргээн босгох хөтөлбөр, бодлогыг хэрэгжүүлэх сайн туршлага, сургамж, мэдээлэл солилцоог дэмжсэн стандарт, хууль, дүрэм, үйл ажиллагааны удирдамж, бусад зааварчилгааны арга хэрэгслийг боловсронгуй болгох, түгээн дэлгэрүүлэх;

в) “Уур амьсгалын үйлчилгээний дэлхийн хөтөлбөр”-т нийцүүлэн аюулын төрлүүдээр үр дүнтэй, улс орнууд хэрэглэхэд тохиромжтой, бүсийн эрт зарлан мэдээлэх механизмыг боловсронгуй болгох, хөрөнгө оруулахыг дэмжих, улс орнуудын мэдээлэл харилцан солилцоход дэмжлэг үзүүлэх;

г) Улс орон, холбогдох бүх талууд мэдлэг, туршлагаа харилцан солилцох Олон улсын сэргээн босгох платформ болон бусад олон улсын механизмыг өргөжүүлэн хөгжүүлэх;

д) Устай холбоотой гамшгийн эрсдэл, түүний нийгэмд үзүүлэх нөлөөллийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, улс орнуудын хүсэлтэд үндэслэн гамшгийн эрсдэлийг бууруулах стратегийг хөгжүүлэх зорилгоор ус, цаг уурын талаарх олон улсын механизмыг хэрэгжүүлэх, бэхжүүлэхэд НҮБ-ын холбогдох байгууллагуудад дэмжлэг үзүүлэх;

е) Дасгал сургууль зохион байгуулах зэргээр гамшгийн бэлэн байдлыг хангахад чиглэсэн бүсийн хамтын ажиллагааг дэмжих;

ё) Гамшгийн үед болон дараа хор уршгийг арилгах чадавх, нөөц солилцоог дэмжих бүсийн протоколыг дэмжих;

ж) Ажиллах хүч, сайн дурынхныг гамшгийн хор уршгийг арилгах ажиллагаанд сургах.

V. Холбогдох талуудын үүрэг, хариуцлага

35. Гамшгийн эрсдэлийг бууруулах үндсэн үүргийг улс орнууд хүлээх боловч энэ нь Засгийн газар, холбогдох талуудын хамтран хүлээх үүрэг хариуцлага байна. Ялангуяа улс орны үндэсний бодлого, хууль, дүрэм журамд нийцүүлэн үйл ажиллагааны хүрээг орон нутгийн, үндэсний, бүсийн болон олон улсын түвшинд хэрэгжүүлэхэд төрийн бус байгууллагууд дэмжлэг үзүүлж, чухал үүрэг гүйцэтгэдэг. Тэдний үүрэг амлалт, хүсэл зориг, мэдлэг, туршлага, нөөц чухал хэрэгцээтэй.

36. Улс орнууд холбогдох талуудын үүрэг, хариуцлагыг тодорхойлохдоо одоо хэрэгжиж буй олон улсын холбогдох арга хэрэгсэлд тулгуурлахын зэрэгцээ төрийн

болон хувийн салбарын холбогдох талуудыг дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг хөхиүлэн дэмжих хэрэгтэй. Үүнд:

а) Иргэний нийгэм, сайн дурынхан, сайн дурын зохион байгуулалттай байгууллага болон олон нийтэд түшиглэсэн байгууллагууд нь: төрийн байгууллагуудтай хамтран гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөө, стандарт, норм, нормативийг боловсруулах, хэрэгжүүлэх талаар тодорхой мэдлэг, практик заавар, чиглэл өгөх үйл ажиллагаанд оролцох; орон нутгийн, үндэсний, бүсийн болон олон улсын түвшний төлөвлөгөө, стратегийг хэрэгжүүлэхэд оролцох; олон нийтийн гамшгийн эрсдэлийн талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, урьдчилан сэргийлэх соёлыг төлөвшүүлэх үйл ажиллагааг дэмжих, хувь нэмэр оруулах; холбогдох байгууллага, талуудын бие биенээ дэмжсэн, харилцан уялдаа бүхий үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хамтын хүчин чармайлтыг хэрэгжүүлсэн гамшгийн эрсдэлийн менежмент, гамшигтай тэмцэх чадавхтай олон нийтийг бий болгох итгэл үнэмшлийг төрүүлэх. Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэхдээ дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй. Үүнд:

- I. Гамшгийн эрсдэлийг үр дүнтэй удирдах, жендерийн мэдрэмжтэй гамшгийн эрсдэлийг бууруулах бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулах, нөөцөөр хангах, хэрэгжүүлэхэд эмэгтэйчүүдийн оролцоо чухал ач холбогдолтой. Эмэгтэйчүүдийн гамшгийн бэлэн байдлыг хангах, гамшгийн дараа амьжиргааны нэмэлт эх үүсвэр бий болгоход шаардлагатай чадавх бэхжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;
- II. Хүүхэд, залуус өөрчлөлт хийхэд нөлөөлдөг учраас үндэсний хууль, тогтоомж, практик үйл ажиллагаа, боловсролын хөтөлбөрт нийцүүлэн гамшгийн эрсдэлийг бууруулахад хувь нэмэр оруулах боломж олгох хэрэгтэй;
- III. Гамшгийн эрсдэлийг үнэлэх, нийтлэг зарчмыг тооцож, онцлог хэрэгцээ, шаардлагад нийцсэн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, холбогдох байгууллагууд чухал үүрэгтэй;
- IV. Ахмадууд гамшгийн эрсдэлийг бууруулахад үнэлж баршгүй капитал болох олон жилээр хуримтлуулсан мэдлэг, чадвар, мэргэн ухаантай байдаг тул тэднийг эрт зарлан мэдээлэх болон бусад бодлого, төлөвлөгөө, механизмыг боловсруулахад оролцуулах хэрэгтэй;
- V. Нутгийн уугуул иргэд уламжлалт мэдлэг, туршлагаараа эрт зарлан мэдээлэх болон бусад төлөвлөгөө, механизмыг боловсруулах, хэрэгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулдаг;
- VI. Шилжин суурьшигсад нь нийгэм, олон нийтийн гамшигтай тэмцэх чадавхийг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулдаг бөгөөд тэдний мэдлэг, чадвар, чадавхийг гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг боловсруулах, хэрэгжүүлэхэд ашиглаж болно.

б) Академи, шинжлэх ухаан, судалгааны байгууллагууд, сүлжээнүүд нь: урт болон дунд хугацаанд шинээр бий болж буй гамшгийн эрсдэл зэрэг эрсдэлийн хүчин зүйлс, нөхцөл байдалд анхаарал хандуулах; бүсийн, үндэсний болон орон нутгийн түвшинд ашиглах судалгааг нэмэгдүүлэх; орон нутгийн олон нийт, засаг захиргааны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх; шийдвэр гаргах үйл явцад бодлого, шинжлэх ухааны харилцан нөлөөллийг тооцоход дэмжлэг үзүүлэх;

в) Бизнесийн болон мэргэжлийн холбоод, санхүүгийн болон нягтлан бодох бүртгэлийн байгууллага зэрэг хувийн хэвшлийн санхүүгийн байгууллагууд, хүмүүнлэгийн сангууд нь: ялангуяа бичил, жижиг, дунд үйлдвэрлэлд гамшгийн эрсдэлийг тооцсон хөрөнгө оруулалт хийж, бизнесийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах зэргээр бизнесийн загвар, үйл ажиллагаанд гамшгийн эрсдэлийн менежментийг тусгах; ажилтнууд, үйлчлүүлэгчдийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, сургалт зохион байгуулах; гамшгийн эрсдэлийн менежментийн технологийн хөгжил, судалгаа, шинэ санаачлагыг дэмжих, оролцох; мэдлэг, туршлага, нийтийн зориулалттай мэдээлэл түгээх, харилцан солилцох; төрийн байгууллагын удирдлага дор гамшгийн эрсдэлийн менежментийг тусган техникийн стандарт, норм, норматив боловсруулахад идэвхтэй оролцох;

г) Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь: үндэсний эрх бүхий байгууллагуудтай нягт хамтран орон нутгийн, үндэсний, бүсийн болон олон улсын бүх түвшинд олон нийтийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, гамшгийн эрсдэл, аюул, гамшгийн талаарх олон нийтэд зориулсан үнэн бодит мэдээллийг энгийн, нээлттэй, ойлгоход хялбар, хүртээмжтэй байдлаар түгээн дэлгэрүүлэхэд идэвхтэй оролцох; гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн харилцаа холбооны тодорхой бодлоготой болох; эрт зарлан мэдээлэх систем, ард иргэдийн амь насыг аврах, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх; үндэсний онцлогт нийцүүлэн нийгмийн бүх түвшинд тогтвортой хэрэгжиж буй олон нийтийн боловсролыг дээшлүүлэх кампанит ажил, хэлэлцүүлэгт олон нийтийн оролцуулах, урьдчилан сэргийлэх соёлыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

37. НҮБ-ын Ерөнхий ассемблейн 2013 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 68/211 тоот тогтоолын дагуу холбогдох талуудын хүлээх үүрэг, хариуцлага нь энэхүү үйл ажиллагааны хүрээг хэрэгжүүлэх, хамтран ажиллах арга хэлбэрийг тодорхойлоход чухал ач холбогдолтой. Эдгээр үүрэг, хариуцлага нь орон нутгийн, үндэсний, бүсийн болон олон улсын түвшинд түншлэлийг хөгжүүлэх, үндэсний ба орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах стратеги, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийн тулд онцлог бөгөөд тодорхой цаг хугацаатай байх хэрэгтэй. Холбогдох бүх талууд энэхүү үйл ажиллагааны хүрээ, үндэсний болон орон нутгийн гамшгийн эрсдэлийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хүлээх үүрэг, хариуцлага, тэдгээрийн хэрэгжилтийн талаар НҮБ-ын Гамшгийн аюулыг бууруулах олон улсын стратегийн газрын цахим хуудсанд нийтлэх нь зүйтэй.

VI. Олон улсын түншлэл, хамтын ажиллагаа

Ерөнхий зүйл

38. Энэхүү үйл ажиллагааны хүрээг хэрэгжүүлэх чадавх, цар хүрээ, авч буй дэмжлэг, туслалцааны түвшин, ялгавартай байдлаас хамаарч, хөгжиж буй орнуудыг хөгжлийн олон улсын түншлэл, хамтын ажиллагааны шугамаар цагаа олсон хэрэгцээт нөөц зэрэг хэрэгслээр тогтвортой хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах хүчин чармайлтыг нь бэхжүүлэхэд олон улсын дэмжлэгийг үргэлжлүүлэн үзүүлэх шаардлагатай байдаг.

39. Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын хамтын ажиллагаа нь олон эх үүсвэртэй бөгөөд хөгжиж буй орнуудын гамшгийн эрсдэлийг бууруулах хүчин чармайлтыг дэмжихэд чухал үүрэгтэй.

40. Улс орнуудын эдийн засаг, технологийн хөгжил, дэвшил, судалгааны чадавхийн ялгааг арилгахын тулд энэхүү үйл ажиллагааны хүрээг хэрэгжүүлэх явцад хөгжингүй орнуудаас хөгжиж буй орнууд руу мэдлэг, ур чадвар, санаа, ноу-хау, технологи урсах нөхцлийг бүрдүүлэх, технологи дамжуулах үйл явцыг өргөжүүлэн хөгжүүлэх нь чухал ач холбогдолтой.

41. Гамшигт өртөмтгий хөгжиж буй орнууд, ялангуяа буурай хөгжилтэй, арлын жижиг болон далайд гарцгүй хөгжиж буй орнууд, Африкийн орнууд, тодорхой бэрхшээлтэй тулгараад буй дундаж орлоготой орнуудын эрсдэл, эмзэг байдлын түвшин өндөр, гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох чадавхаас ихэнхдээ даван гарч байгаа нь олон улсын анхаарлыг зүй ёсоор татаж байна. Энэ эмзэг байдал нь хөгжиж буй орнуудын үндэсний хэрэгцээ шаардлага, тэргүүлэх чиглэлд нийцүүлэн үйл ажиллагааны хүрээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх олон улсын хамтын ажиллагааг яаралтай бэхжүүлэх, бүсийн болон олон улсын түвшинд бодит, бат бөх түншлэлийг бий болгохыг шаардаж байна. Олон жижиг арлаас бүрдсэн, урт үргэлжилсэн эргийн шугамтай зэрэг онцлогтой гамшигт өртөмтгий бусад орнуудад мөн анхаарал хандуулж, шаардлагатай тусламжийг үзүүлэх хэрэгтэй.

42. Арлын жижиг хөгжиж буй орнууд онцлог шинж чанар, эмзэг байдлаасаа шалтгаалан гамшигт харилцан адилгүй өртдөг. Уур амьсгалын өөрчлөлтөөс гамшгийн нөлөөлөл, эрчим улам бүр нэмэгдэж байгаа нь эдгээр орнуудын тогтвортой хөгжлийн ахиц дэвшилд саад учруулж байна. Арлын жижиг хөгжиж буй орнуудын хувьд гамшгийн эрсдэлийг бууруулах хүрээнд “Арлын хөгжиж буй жижиг орнуудын үйл ажиллагааны хурдавчилсан загвар” (SIDS Accelerated Modalities of Action (SAMA) Pathway)⁹-ын үр дүнг хэрэгжүүлэх замаар тодорхой дэмжлэг үзүүлэх, гамшигтай тэмцэх чадавхийг бэхжүүлэх чухал шаардлагатай байна.

43. Африкийн орнуудад тохиолдож буй гамшиг, өсөн нэмэгдэж байгаа эрсдэлтэй холбоотойгоор амьжиргаа, эрүүл мэнд, дэд бүтцийн гамшиг тэсвэрлэх чадавхийг бэхжүүлэх зэрэг хүндрэл бэрхшээл тулгарсаар байна. Эдгээр

⁹ Ерөнхий Ассамблейн 69/15 тогтоол, хавсралт

бэрхшээлийг шийдвэрлэх, энэхүү үйл ажиллагааны хүрээг хэрэгжүүлэхийн тулд олон улсын хамтын ажиллагааг сайжруулах, Африкийн орнуудад шаардлагатай дэмжлэг туслалцааг үзүүлэх хэрэгтэй байна.

44. Өмнөд-өмнөдийн болон гурвалсан хамтын ажиллагаагаар дэмжигдсэн Хойд-өмнөдийн хамтын ажиллагаа гамшгийн эрсдэлийг бууруулахад чухал ач холбогдолтой болох нь нотлогдсон бөгөөд цаашид эдгээр хоёр бүс нутагт нь хамтын ажиллагааг бэхжүүлэх шаардлага байсаар байна. Түншлэл нь улс орны нөөц бололцоог бүрэн ашиглах, гамшгийн эрсдэлийн менежментийн үндэсний чадавхийг сайжруулах, иргэд, олон нийт, улс орны нийгэм, эдийн засаг, эрүүл мэндийн сайн сайхан аж байдлыг дээшлүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

45. Хөгжиж буй орнуудын санаачилсан Өмнөд-өмнөдийн ба гурвалсан хамтын ажиллагаа нь хөгжингүй орнуудын хэрэгжүүлж буй Хойд-өмнөдийн хамтын ажиллагаанд хувь нэмэр оруулж байна.

46. Төрийн болон хувийн хэвшил найдвартай, боломжийн үнэтэй, хэрэгцээ хангасан, орчин үеийн, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүй технологийг харилцан тохиролцсон, хөнгөлөлттэй нөхцлөөр солилцоход олон улсын төрөл бүрийн эх сурвалжаас санхүүгийн дэмжлэг үзүүлэх; хөгжиж буй орнуудын чадавхийг бэхжүүлэхэд тусламж үзүүлэх; бүх түвшинд институцийн болон бодлогын таатай орчинг бүрдүүлэх нь гамшгийн эрсдэлийг бууруулахад маш чухал ач холбогдолтой.

Хэрэгжүүлэх арга хэлбэрүүд

47. Дээрх зорилтод хүрэхийн тулд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

а) Хөгжиж буй орнууд, нэн ялангуяа буурай хөгжилтэй орнууд, арлын жижиг болон далайд гарцгүй хөгжиж буй орнууд, Африкийн орнууд, түүнчлэн тодорхой бэрхшээл тулгараад буй дундаж орлоготой орнуудад хоёр талт ба олон талт сувгаар техник, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, харилцан тохиролцсон хөнгөлөлттэй нөхцлөөр технологи шилжүүлэх зэргээр чадавхийг бэхжүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулахад зохицуулалттай, тогтвортой, хэрэгцээ шаардлагыг хангасан олон улсын тусламж шаардлагатай байгааг дахин баталгаажуулах;

б) Улс орнууд, ялангуяа хөгжиж буй орнуудын санхүү, хүрээлэн буй орчинд ээлтэй технологи, шинжлэх ухааны бүтээл, мэдлэг, мэдээллийн солилцооны хүртээмжийг одоо байгаа механизм, тухайлбал НҮБ, холбогдох бусад байгууллагуудын хоёр талт, бүсийн, олон талт хамтын ажиллагааны зохицуулалтаар өргөжүүлэх;

в) Дэлхийн технологийн сан, ноу-хау, инновац болон судалгаа солилцох дэлхийн систем зэрэг хамтын ажиллагааны сэдэвчилсэн платформуудыг ашиглах, өргөжүүлэх явдлыг дэмжих, гамшгийн эрсдэлийг бууруулахад мэдээлэл, технологи авах боломжийг бүрдүүлэх;

г) Ядуурлыг бууруулах, тогтвортой хөгжил, байгалийн нөөцийн менежмент, хүрээлэн буй орчин, хот байгуулалт, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох зэрэг салбарын болон салбар хоорондын хоёр талт, олон талт хөгжлийн тусламжийн хөтөлбөрүүдэд гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг тусгах.

Олон улсын байгууллагуудаас үзүүлэх дэмжлэг

48. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд дараах үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

а) НҮБ, бусад олон улсын болон бүсийн байгууллагууд, санхүүгийн институтиуд, хандивлагч байгууллагуудыг гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд оролцохыг хүсэх, үүнтэй холбоотойгоор стратеги, бодлогынхоо зохицуулалтыг сайжруулах;

б) НҮБ-ын төрөлжсөн агентлагууд, сан, хөтөлбөрүүд болон НҮБ-ын системийн бусад байгууллагууд эрх, үүргийнхээ хүрээнд НҮБ-ын Гамшигтай тэмцэх чадавхийг бэхжүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөө, Хөгжлийн тусламжийн хүрээ болон тухайн улсад хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдээрээ нөөцийн үр ашигтай хэрэглээг дэмжих, хөгжиж буй орнуудын хүсэлтээр энэхүү үйл ажиллагааны хүрээг холбогдох бусад үйл ажиллагааны хүрээ, тухайлбал Олон улсын эрүүл мэндийн дүрэм (2005)-тэй нийцүүлэн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, чадавхийг бэхжүүлэх, улс, орны тэргүүлэх чиглэлүүдээр тэнцвэртэй, зохицуулалт сайтай хөтөлбөрүүдийг тогтвортой хэрэгжүүлэх;

в) НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын стратегийн газраас энэхүү үйл ажиллагааны хүрээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтийг хянах. Үүнд: НҮБ-ын хяналтын үйл явцын дагуу ялангуяа Дэлхийн платформын хэрэгжилтээр тодорхой хугацаанд тогтмол хяналтыг зохион байгуулах, тогтвортой хөгжил, уур амьсгалын өөрчлөлтийн холбогдох бусад механизмд нийцүүлэн олон улс, бүсийн түвшинд харилцан уялдаатай хяналтыг зохион байгуулах, шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх, Хёогогийн үйл ажиллагааны хүрээний хэрэгжилтэд мониторинг хийх вэбд суурилсан системийг шинэчлэх; Тогтвортой хөгжлийн шалгуур үзүүлэлтийн асуудлаарх байгууллага хоорондын болон мэргэжилтнүүдийн бүлгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох; улс орнуудтай нягт хамтран ажиллаж, холбогдох мэргэжилтнүүдийн тусламжтай энэхүү үйл ажиллагааны хүрээг хэрэгжүүлэх баримт нотолгоонд үндэслэсэн практик зааварчилгаа боловсруулах; мэргэжилтнүүд, техникийн байгууллагууд стандарт боловсруулах, ухуулга сурталчилгаа хийх, гамшгийн эрсдэлийн мэдээлэл, бодлого, үйл ажиллагааг түгээх, холбогдох байгууллагуудын тусламжтай гамшгийн эрсдэлийг бууруулах сургалт зохион байгуулах, боловсрол олгоход дэмжлэг үзүүлэн холбогдох талуудын урьдчилан сэргийлэх соёлыг бэхжүүлэх; улс орнуудад үндэсний платформ, бусад ижил төрлийн арга хэрэгслээр дамжуулан үндэсний төлөвлөгөө боловсруулах, гамшгийн эрсдэл, хохирол, нөлөөллийн төлөв, чиг хандлагад хяналт тавихад дэмжлэг үзүүлэх; Гамшгийн эрсдэлийг бууруулах дэлхийн платформыг хуралдуулах, бүсийн

байгууллагуудтай хамтран бүсийн хэмжээнд гамшгийн эрсдэлийг бууруулах платформ зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх; НҮБ-ын Гамшигтай тэмцэх чадавхийг бэхжүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг удирдан зохион байгуулах; Олон улсын гамшгийн эрсдэлийг бууруулах бага хурлын Шинжлэх ухаан, техникийн зөвлөлдөх бүлгийн гамшгийн эрсдэлийг бууруулах шинжлэх ухаан, техникийн ажлыг сайжруулах, үргэлжлүүлэхэд дэмжлэг үзүүлэх; бусад орнуудтай нягт хамтран, зөвшилцөн тохиролцсоны үндсэн дээр 2009 онд гаргасан “Гамшгийн эрсдэлийг бууруулах нэр томъёо”-г шинэчлэх; холбогдох талуудын хүлээсэн үүрэг, амлалтыг бүртгэх ажлыг зохион байгуулах;

г) Дэлхийн банк, бүсийн хөгжлийн банкууд зэрэг олон улсын санхүүгийн институтиуд хөгжиж буй орнуудын гамшгийн эрсдэлийг бууруулахад зориулан санхүүгийн дэмжлэг үзүүлэх, зээл олгохдоо энэхүү үйл ажиллагааны хүрээнд тусгасан тэргүүлэх чиглэлүүдэд анхаарал хандуулах;

д) НҮБ-ын Уур амьсгалын асуудлаарх суурь конвенцэд нэгдсэн талуудын бага хурал, олон улсын болон бүсийн түвшний олон улсын санхүүгийн байгууллагууд, Олон улсын улаан загалмай, улаан хавирган сар хөдөлгөөн, олон улсын болон гэрээний бусад байгууллагууд хөгжиж буй орнуудын хүсэлтэд үндэслэн энэхүү үйл ажиллагааны хүрээг холбогдох бусад баримт бичигтэй зохицуулан хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

е) Хувийн хэвшил, бизнесийн салбартай хамтран ажиллах зорилгоор санаачилсан НҮБ-ын Глобал компакт нь тогтвортой хөгжил, гамшигтай тэмцэх чадавхийг бэхжүүлэхэд гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны ач холбогдлыг чухалчилж, цаашид хамтран ажиллах;

ё) НҮБ-ын Гамшгийн аюулыг бууруулах итгэлцлийн санд өгөх хандивын хэмжээг нэмэгдүүлэх, тодорхой хугацаанд тогтмол хийх зэрэг санхүүжилтийн төрөл бүрийн механизмаар хүрэлцээтэй нөөц бүрдүүлэх, энэхүү үйл ажиллагааны хүрээг хэрэгжүүлэхтэй холбоотой тус Сангийн гүйцэтгэх үүргийг өргөжүүлэх зэргээр хөгжиж буй орнуудын гамшгийн эрсдэлийг бууруулахад дэмжлэг туслалцаа үзүүлэх НҮБ-ын системийн чадавхийг бэхжүүлэх;

ж) Парламент хоорондын холбоо, парламентын гишүүдтэй холбоотой бусад бүс нутгийн байгууллага, механизмууд гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг ухуулан сурталчлах, үндэсний хууль, эрх зүйн орчинг сайжруулахад үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлэх;

з) Хот, орон нутгийн засаг захиргааны нэгдсэн байгууллага болон орон нутгийн засаг, захиргааны холбогдох бусад байгууллагууд гамшгийн эрсдэлийг бууруулах болон энэхүү үйл ажиллагааны хүрээг хэрэгжүүлэх чиглэлээр орон нутгийн засаг захиргааны хамтын ажиллагаа, харилцан суралцах явдлыг үргэжлүүлэн дэмжих.

Хэрэгжилтийг хянах үйл ажиллагаа

49. Бага хурлаас Гамшгийн эрсдэлийг бууруулах дэлхийн платформ, гамшгийн эрсдэлийг бууруулах бүсийн платформууд, Хёогогийн үйл ажиллагааны хүрээний хэрэгжилтийн мониторингийн үр дүн, хувь нэмрийг харгалзан гамшгийн эрсдэлийг бууруулах энэхүү үйл ажиллагааны хүрээний дэлхийн хэрэгжилтийг Эдийн засаг, нийгмийн зөвлөл, Тогтвортой хөгжлийн өндөр түвшний улс төрийн форум, бодлогын хэрэгжилтийг хянах дөрвөн жилийн циклтэй зэрэгцүүлэн нэгдсэн, зохион байгуулалттай хянах үйл явцынхаа нэг хэсэг болгон НҮБ-ын бага хурал, дээд хэмжээний уулзалтуудад тусгах боломжийг Ерөнхий ассемблейн 70 дугаар чуулганаар авч үзэхийг хүссэн.

50. Бага хурал Ерөнхий ассемблейд 69 дүгээр чуулганыхаа үеэр энэхүү үйл ажиллагааны хүрээний дэлхийн хэрэгжилтийг хэмжих багц шалгуур үзүүлэлтүүдийг тогтвортой хөгжлийн шалгуур үзүүлэлт боловсруулах байгууллага хоорондын мэргэжилтнүүдийн бүлгийн ажилтай уялдуулан боловсруулах, гишүүн орнуудаас нэр дэвшүүлсэн мэргэжилтнүүдээс бүрдсэн, холбогдох талуудын оролцоог хангасан, НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын стратегийн газрын дэмжлэгтэй засгийн газар хоорондын нээлттэй ажлын хэсэг байгуулахыг зөвлөмж болгосон. Түүнчлэн энэхүү ажлын хэсгийг НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын стратегийн газраас 2009 онд гаргасан “Гамшгийн эрсдэлийг бууруулах нэр томъёо”-г 2016 оны 12 дугаар сараас өмнө шинэчлэх тухай Шинжлэх ухаан, техникийн зөвлөлдөх бүлгийн зөвлөмжийг харгалзаж үзэхийг зөвлөсөн бөгөөд энэхүү ажлын үр дүнг Ерөнхий ассемблейгаар хэлэлцүүлж батлуулахаар өргөн барих юм.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Орон нутгийн түвшинд гамшгийн эрсдэлийг бууруулах менежмент, зохицуулалтын чадавхийг сайжруулах нь” МОН13/301 төслөөс орчуулав.

---oOo---